



2021 оны 09 дүгээр сарын 21
Тусгай дугаар №14

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Тусгай дугаар
XIV БОТЬ

МОНГОЛ УЛСЫН
ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

АЗИ, НОМХОН ДАЛАЙН
ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР

ᠲᠦᠰᠭᠠᠢ ᠳᠤᠭᠠᠭᠠᠷ
ᠬᠢᠶᠢᠪᠠᠳᠤ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠭᠡᠷᠡᠭᠡ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠭᠡᠷᠡᠭᠡ
ᠬᠢᠶᠢᠪᠠᠳᠤ



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ ТУСГАЙ ДУГААР XIV БОТЬ

ГАРЧИГ

171. АЗИ, НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР

1. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр.....	3819
Хавсралт I: Үндэсний хөнгөлөлтийн жагсаалт	
1. Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс	
1.1 Үндэсний хөнгөлөлтийн жагсаалт	3832
1.2 Нэн буурай хөгжилтэй улсад үзүүлэх хөнгөлөлтийн жагсаалт	3852
2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс	
2.1 Хөнгөлөлтийн үндэсний жагсаалт	3852
2.2 Хөнгөлөлтийн үндэсний жагсаалт (тусгай).....	3949
3. Бүгд Найрамдах Энэтхэг Улс	
3.1 Хөнгөлөлтийн үндэсний жагсаалт	3957
3.2 Нэн буурай хөгжилтэй улсад үзүүлэх хөнгөлөлтийн жагсаалт	4044
4. Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс	
4.1 Хөнгөлөлтийн үндэсний жагсаалт	4046
5. Монгол Улс	
5.1 Хөнгөлөлтийн үндэсний жагсаалт	4077
6. Бүгд Найрамдах Солонгос Улс	
6.1 Хөнгөлөлтийн үндэсний жагсаалт	4096
6.2 Бангладеш Улсад үзүүлэх хөнгөлөлтийн жагсаалт	4173
6.3 Лаос Улсад үзүүлэх хөнгөлөлтийн жагсаалт.....	4197
7. Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улс	
7.1 Хөнгөлөлтийн үндэсний жагсаалт	4223
7.2 Нэн буурай хөгжилтэй улсад үзүүлэх хөнгөлөлтийн жагсаалт	4243
Хавсралт II: Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн гарал	
үүслийн дүрэм.....	4247
Хавсралт II.A Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн салбарын	
гарал үүслийн дүрэм.....	4253

- | | |
|---|------|
| 2. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн оролцогч улсад худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр..... | 4255 |
| 3. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн оролцогч улс хооронд үйлчилгээний худалдааг идэвхжүүлэх, чөлөөлөх тухай Ерөнхий хэлэлцээр..... | 4260 |
| 4. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн оролцогч улс хооронд хөрөнгө оруулалтыг чөлөөлөх тухай Ерөнхий хэлэлцээр..... | 4267 |
| 5. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн хоёр дахь нэмэлт, өөрчлөлт | 4275 |
| 6. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн хүрээнд барааны гарал үүслийг нотлох гэрчилгээ олгож, баталгаажуулах үйл ажиллагааны журам..... | 4276 |

171. АЗИ, НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР

1975 онд Бангкокийн хэлэлцээр нэрээр гарын үсэг зурж,
2005 оны 11 дүгээр сарын 2-нд нэрээ өөрчилсөн¹

АЗИ, НОМХОН ДАЛАЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН КОМИССЫН ХӨГЖИЖ БУЙ ГИШҮҮН УЛС ХООРОНДЫН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭНИЙ ТУХАЙ АНХНЫ ХЭЛЭЛЦЭЭР (БАНГКОКИЙН ХЭЛЭЛЦЭЭР)-ИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

ОРШИЛ

Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлаарх Сайд нарын Зөвлөлөөс гаргасан Кабулын тунхаглалын шийдвэр, уг тунхаглалаар бий болгосон Худалдааг өргөжүүлэх хөтөлбөрийн Засгийн газар хоорондын хорооноос баталсан Азийн худалдааг өргөжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын (АНДЭЗНК) хөгжиж буй гишүүн улс хооронд худалдааг өргөжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатайг хүлээн зөвшөөрч;

Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын 31 дүгээр чуулганаас баталсан Шинэ Делигийн тунхаглалын зарчмыг удирдлага болгон;

Худалдааг өргөжүүлэх нь төрөлжилт болон эдийн засгийн цар хүрээний өгөөжөөр дамжин хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн боломжийг нэмэгдүүлж, улмаар ажил эрхлэлт болон хүн амын амьжиргааны түвшинг ахиулан бататгах үндэсний эдийн засгийн хөгжлийн чухал хөшүүрэг болохыг ухамсарлан;

Бараа бүтээгдэхүүний бие биеийн зах зээлд нэвтрэх тааламжтай нөхцөл, боломжийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэл, худалдааг өргөжүүлэх, гадагш чиглэсэн зохистой хандлагыг дэмжсэн худалдааны зохицуулалтыг хөгжүүлэх нь чухал ач холбогдолтойг анхааран;

Хөгжиж буй улс хооронд хөнгөлөлтийн тогтолцоо бий болгох нь чухал болохыг олон улсын болон бүс нутгийн түвшинд нэн ялангуяа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хоёр дахь арван жилийн Олон улсын хөгжлийн стратеги, Олон улсын эдийн засгийн шинэ дэглэм бий болгох тухай тунхаглал болон Олон улсын эдийн засгийн шинэ дэглэм бий болгох үйл ажиллагааны хөтөлбөрийн талаарх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоол, НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын хоёрдугаар чуулга уулзалт (ЮНКТАД-II)-аас баталсан Хөгжиж буй улс хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, бүс нутгийн интеграцын тухай нэгдсэн тунхаглал, түүнчлэн Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 4 дүгээр бүлэг, Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийн 5 дугаар зүйл болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан шийдвэрийн хүрээнд олон улсын хамтын нийгэмлэг бүрэн хүлээн зөвшөөрснийг тэмдэглэн;

Түүнчлэн хөгжиж буй улсууд энэ төрлийн хөнгөлөлтийн зохицуулалтыг өөр хоорондоо хэрэглэх зорилгоор Худалдааны хөнгөлөлтийн бүх нийтийн тогтолцоог бий болгох зэрэг зарим чухал шийдвэр гаргасныг тэмдэглэн;

Олон улсын бусад форумын хүрээнд гарч буй хүч чармайлтыг дэмжин Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын хөгжиж буй гишүүн улс хооронд хөнгөлөлтийн тогтолцоо бий болгох нь хөгжиж буй улс хоорондын худалдааг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр болно гэдэгт итгэн;

Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улсын Засгийн газар дараах зүйлийг ТОХИРОЛЦОВ:

¹Монгол Улс 2019.12.12-нд соёрхон баталсан.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл

Тодорхойлолт

Энэхүү хэлэлцээрийн зорилгоор дараах тодорхойлолтыг хэрэглэнэ. Үүнд:

1) “Оролцогч улс” гэж нэгдэн орох, эсхүл соёрхон батлах тухай батламж жуух бичгээ АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн даргад хадгалуулан тус хэлэлцээрийг заавал биелүүлэхээ зөвшөөрсөн улсыг;

2) “Анхдагч оролцогч улсууд” гэж Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улсыг;

3) “АНДЭЗНК-ын хөгжиж буй гишүүн улс” гэж Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын үйл ажиллагааны журмын 3 ба 4 дүгээр хэсэгт болон журмын нэмэлт, өөрчлөлтөд багтсан улсыг;

4) “Нэн буурай хөгжилтэй улс” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагаас ийнхүү нэрлэсэн улсыг;

5) “Бараа” гэж түүхий, хагас боловсруулсан, боловсруулсан хэлбэрт байгаа болон бусад бүх бараа бүтээгдэхүүнийг;

6) “Ижил бараа” гэж тухайн бараатай адил, эсхүл тухайн бараа байхгүй нөхцөлд тухайн барааны шинж чанартай ойр төсөө бүхий адил биш барааг;

7) “Тариф” гэж оролцогч улсын үндэсний тарифын жагсаалтад багтсан гаалийн татварыг;

8) “Хилийн төлбөр, хураамж” гэж гадаад худалдааны гүйлгээнд ногдуулж буй, тарифын адил үр нөлөөтэй, зөвхөн импортын бараанд ногдуулдаг тарифаас бусад хилийн төлбөр, хураамж боловч дотоодын ижил бараанд ногдуулдаг шууд бус татвар, хураамж биш. Тодорхой үйлчилгээтэй холбогдох импортын төлбөрийг хилийн төлбөр, хураамж гэж үзэхгүй;

9) “Тарифын бус арга хэмжээ” гэж импортыг хязгаарлах, эсхүл худалдааг мэдэгдэхүйц гажуудуулах нөлөө бүхий тариф, хилийн төлбөр, хураамжаас бусад аливаа арга хэмжээ, журам, эсхүл жишгийг;

10) “Хөнгөлөлтийн хэмжээ” гэж Нэн тааламжтай үндэстний нөхцөл (НТҮН)-ийн татварын хувь хэмжээ болон ижил бараанд ногдуулах хөнгөлөлттэй татварын хувийн зөрүүг хэлэх боловч тэрхүү хувь хэмжээ хоорондын шууд ялгаа биш. Тиймээс,

Хөнгөлөлтийн хэмжээ=

$$\frac{\text{(НТҮН татвар-хэлэлцээрийн дагуу зөвшөөрөгдсөн тарифын хэмжээ)}}{\text{НТҮН татвар}} \times 100\%$$

11) “Хөнгөлөлтийн үнэлгээ” гэж энэхүү хэлэлцээрийн хүрээнд тохиролцсон Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтын дагуу нэг Оролцогч улсаас бусад улсад олгож буй тарифын болон тарифын бус хөнгөлөлтөөс авах ашгийн хэмжээг. Тарифын хөнгөлөлтийн хувьд хөнгөлөлтийн хэмжээ нь тогтвортой байвал хөнгөлөлтийн үнэлгээг хадгалсанд тооцно;

12) “Ноцтой хохирол” гэж хөнгөлөлтийн үр дүнд барааны импорт их хэмжээгээр нэмэгдэж, улмаар дотоодын ижил, төстэй бараа үйлдвэрлэгчдийг орлого, үйлдвэрлэлийн

хувьд их хэмжээний алдагдалд оруулах, ажил эрхлэлтийг богино хугацаанд тогтворгүй байдалд хүргэх зэрэг ихээхэн хэмжээний хохирлыг. Дотоодын үйлдвэрлэлд үзүүлэх нөлөөллийн шинжилгээнд тухайн барааны дотоодын үйлдвэрлэлд үзүүлж буй эдийн засгийн бусад холбогдох хүчин зүйл болон тухайн барааны үйлдвэрлэлийн байдлын үзүүлэлтийн үнэлгээг хамааруулна;

13) “Ноцтой хохирол учруулах аюул” гэж хөнгөлөлттэй импорт үлэмж хэмжээгээр нэмэгдсэнээр дотоодын үйлдвэрлэгчид ноцтой хохирол учруулах нөхцөл буюу хэдийгээр хохирол учруулаагүй боловч учруулж болзошгүй нөхцөлийг. Ноцтой хохирол учруулах аюулыг сэжиг, таамаг, төсөөлөлд бус баримтад тулгуурлан тодорхойлно.

2 дугаар зүйл

Зорилго

Энэхүү хэлэлцээрийн зорилго нь АНДЭЗНК-ын хөгжиж буй гишүүн улс хооронд худалдааг өргөжүүлэх тасралтгүй үйл явцаар дамжуулан эдийн засгийн хөгжлийг дэмжих, түүнчлэн тэдний өнөөгийн болон ирээдүйн худалдааны болон хөгжлийн хэрэгцээнд нийцсэн худалдааг чөлөөлөх харилцан ашигтай арга хэмжээ авах замаар олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаанд ахиц гаргахад оршино.

3 дугаар зүйл

Зарчим

Энэхүү хэлэлцээрт дараах ерөнхий зарчмыг баримтална. Үүнд:

- (i) Хэлэлцээр нь Оролцогч бүх улсад нэгэн адил ашигтай байх замаар харилцан давуу тал олгох, бүхэлдээ харилцан адил байх зарчимд суурилна.
- (ii) Оролцогч улс хоорондын худалдааны харилцаанд ил тод байх зарчим, Үндэсний нөхцөл болон Нэн тааламжтай үндэстний нөхцөлийг мөрдлөг болгоно.
- (iii) Нэн буурай хөгжилтэй Оролцогч улсын онцгой хэрэгцээ нь эргэлзээгүй хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд тэдгээрт үзүүлэх бодит хөнгөлөлтийн арга хэмжээг тохиролцоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХУДАЛДААГ ЧӨЛӨӨЛӨХ ХӨТӨЛБӨР

4 дүгээр зүйл

Хөнгөлөлтийн хэлэлцээ

Энэхүү хэлэлцээр нь (a) тариф, (b) хилийн төлбөр, хураамж, (c) тарифын бус арга хэмжээтэй холбоотой зохицуулалт зэргээс бүрдэнэ. Оролцогч улсууд тарифын хөнгөлөлтийн хэлэлцээг дараах арга зам болон журмын аль нэгийг, эсхүл хослуулан хэрэглэх замаар явуулж болно: (a) бараа тус бүрээр; (b) бүх барааны хувьд тарифыг жигд бууруулах; (c) салбараар. Тарифын хэлэлцээг Оролцогч улс бүрийн одоогийн Нэн тааламжтай үндэстний тарифын хувь хэмжээнд үндэслэнэ. Оролцогч улс энэхүү хэлэлцээрийг өргөжүүлэх болон гэрээний зорилтод бүрэн хүрэх зорилгоор хэлэлцээг тогтмол хийнэ.



5 дугаар зүйл

Хөнгөлөлтийг хэрэглэх

Оролцогч улс бүр бусад бүх оролцогч улсаас гаралтай бараа бүтээгдэхүүнд тариф, хилийн төлбөр, хураамж болон тарифын бус арга хэмжээг өөрийн Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтын дагуу ногдуулна. Эдгээр Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтыг энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг болох 1 дүгээр хавсралтад хавсаргасан болно.

6 дугаар зүйл

Тарифын бус арга хэмжээ

Оролцогч улс бүр Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтад хамаарах бараа, бүтээгдэхүүний импортод нөлөөлж болох тарифын бус арга хэмжээг бага багаар хөнгөвчлөх зорилгоор өөрийн улсын хөгжлийн хэрэгцээ, зорилгод нийцсэн зохистой арга хэмжээг авна. Оролцогч улс хоорондын худалдаан дахь техникийн саад тотгортой холбогдох асуудал, эрүүл ахуйн болон ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын холбогдох заалтын дагуу аль болох бодитоор зохицуулна. Оролцогч улс нь ил тод байх үүднээс хөнгөлөлтөд хамрагдсан бараанд хамаарах тарифын бус арга хэмжээний жагсаалтыг харилцан нээлттэй байлгана.

7 дугаар зүйл

Нэн буурай хөгжилтэй оролцогч улсад үзүүлэх тусгай хөнгөлөлт

Энэхүү хэлэлцээрийн 5 дугаар зүйлд заасныг үл харгалзан, аливаа Оролцогч улс нь Нэн буурай хөгжилтэй оролцогч улсад тусгай хөнгөлөлт олгож болох бөгөөд энэхүү хөнгөлөлт нь Нэн буурай хөгжилтэй оролцогч бүх улсад үйлчлэх боловч бусад Оролцогч улсад хамаарахгүй. Эдгээр тусгай хөнгөлөлт нь хөнгөлөлт үзүүлэгч Оролцогч улсын Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтад орно.

8 дугаар зүйл

Гарал үүслийн дүрэм

Энэхүү хэлэлцээрийн хавсралт болох Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтад багтсан бүтээгдэхүүн нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг болох 2 дугаар хавсралтад заасан Гарал үүслийн дүрмийн шаардлагыг хангасан тохиолдолд хөнгөлөлт эдлэх эрхтэй.

9 дүгээр зүйл

Хөнгөлөлтийн хэмжээг хэвээр хадгалах

Бусад хэсэгт өөрөөр заагаагүй бол, Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтад заасан хөнгөлөлтийн хэмжээг хадгалах зорилгоор Оролцогч улс нь энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш түүнээс өмнө мөрдөж байснаас бусад худалдааг хязгаарлах аливаа төлбөр, арга хэмжээг авах замаар эдгээр хөнгөлөлтийн хэмжээг цуцалж, эсхүл бууруулж болохгүй. Үүнд (а) дотоодын ижил төстэй бүтээгдэхүүнд ногдуулсан дотоодын татвар, (b) демпингийн эсрэг, эсхүл нөхөн төлөөсийн татвар, эсхүл (c) үзүүлсэн үйлчилгээнд тохирсон хураамжтай дүйцэх төлбөр хамаарахгүй.

10 дугаар зүйл

Хөнгөлөлтийн хязгаарыг дахин тогтоох

Хэрэв Оролцогч улс нь тарифаа хянан үзсэний үр дүнд Оролцогч бусад улсад үзүүлж буй хөнгөлөлтийн хэмжээг бууруулах, эсхүл цуцлахаар бол аль болох боломжит хугацаанд тэнцүү хэмжээний хөнгөлөлтийн хэмжээг дахин тогтоох, эсхүл Үндэсний хөнгөлөлтийн

жагсаалтаа харилцан ашигтай байдлаар өөрчлөх зорилго бүхий хэлэлцээг хийх зорилгоор 4 дүгээр бүлэгт заасны дагуу Оролцогч бусад улстай нэн даруй зөвлөгөөн хийж, харилцан зөвшөөрөхүйц нөхөн олговрын арга хэмжээ авна. Энэ зүйлд заасан боломжтой хугацаа гэдэг нь тарифын хяналтын мэдэгдэл гаргасан өдрөөс хойших 6 сараас дээшгүй хугацааг хэлнэ. Энэхүү хугацааг хэтрүүлсэн Оролцогч улс ийнхүү хэтрүүлсэн шалтгааны үндэслэлийг тайлбарлана.

11 дүгээр зүйл

Хэлэлцээрийн хамрах хүрээ

Энэхүү хэлэлцээр нь түүхий, хагас боловсруулсан, боловсруулсан хэлбэрт байгаа бүх бараа бүтээгдэхүүнийг хамарна. Оролцогч улсууд худалдааг чөлөөлөхөд дөхөм болох хилийн болон хилийн бус арга хэмжээний талаар хамтран ажиллах бусад чиглэлийг эрэлхийлнэ. Үүнд: стандартаа уялдуулах, барааны сорилын үнэлгээ, баталгаажуулалтыг харилцан хүлээн зөвшөөрөх, макро эдийн засгийн талаар зөвлөлдөх, худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ, үйлчилгээний худалдаа зэрэг асуудал багтана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУДАЛДААГ ӨРГӨЖҮҮЛЭХ

12 дугаар зүйл

Худалдааг өргөжүүлэх болон төрөлжүүлэх

Худалдааг нэгтгэх, тасралтгүй өргөжүүлэх, улам төрөлжүүлэх зорилгоор Оролцогч улсууд дараах хэсэгт тусгагдсан зорилт болон заалтыг анхаарч ажиллахыг зөвшөөрч, тэдгээрийг үндэсний бодлого, зохицуулалттайгаа нийцүүлэн шуурхай хэрэгжүүлэхийг эрмэлзэнэ. Үүнд:

- a. Оролцогч улс нь аль нэгнийхээ нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй бүтээгдэхүүний импортод энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө үзүүлж байснаасаа дутуугүй тааламжтай нөхцөлийг боломжийн хэмжээгээр харилцан олгоно.
- b. Оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй бараа, бүтээгдэхүүн нь татвар, тариф болон бусад дотоодын татвар, хураамжийн хувьд бусад бүх Оролцогч улсын нутаг дэвсгэрт тухайн Оролцогч улсын дотоодын ижил төстэй бүтээгдэхүүндээ олгож байгаагаас дутуугүй тааламжтай нөхцөл эдэлнэ.
- c. Оролцогч улс нь Оролцогч бусад улсын экспортолж байгаа болон экспортлох сонирхол бүхий бараа, бүтээгдэхүүний татвар, хилийн хураамж, төлбөрийг нэмэгдүүлэхгүй, эсхүл шинээр ногдуулахгүй, тарифын бус саад тотгор учруулахгүй байхыг эрмэлзэнэ. Энэ хэсгийн үйлчлэх хүрээнд хамаарах бүтээгдэхүүнийг тодорхойлох зорилгоор Оролцогч улсууд энэ ангиллын бараа бүтээгдэхүүний жагсаалтыг тухай бүр Байнгын хороонд хүргүүлж шийдвэр гаргуулна.
- d. Шаардлагатай гэж үзвэл, Оролцогч улсууд нь энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, хоорондын худалдааны үйл ажиллагаа, дүрэм журмыг хялбарчлах, стандартчилах зэрэг зорилгоор хамтын ажиллагааны зохих арга хэмжээ, нэн ялангуяа гаалийн удирдлагын чиглэлээрх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Энэ зорилгоор Байнгын хороо нь шаардлагатай захиргааны арга хэмжээг авна.
- e. Оролцогч улсууд 1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр, Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр зэрэг ДХБ-ын холбогдох хэлэлцээрийн заалтыг бодит боломжийн хэмжээнд баримтлан, энэхүү хэлэлцээрийн заалтыг уялдуулан хэрэглэх нөхцөлийг хангана.



- f. Оролцогч улсууд Дэлхийн Гаалийн Холбооны Барааг тодорхойлох, кодлох Уялдуулсан системийн хамгийн сүүлийн хувилбарыг нийтлэг тарифын жагсаалт болгон хэрэглэж, цаашдын хэлэлцээг Уялдуулсан системийн 6 оронд тулгуурлан хийнэ.
- g. Оролцогч улсууд харилцан экспортлох сонирхол бүхий бараа бүтээгдэхүүнд үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээ, хүрээг хэлэлцээ хийх замаар өргөжүүлэх алхам хийнэ. Энэ зорилгоор Байнгын хороо нь хэлэлцээний үйл явцыг түргэтгэх, түүний дотор хэлэлцээ хийх нэмэлт арга, техник болон хэлэлцээ хийх тусгай асуудлыг бий болгох боломжийг агуулсан үйл ажиллагааны хөтөлбөрийг тухай бүр батална.

13 дугаар зүйл

Давуу тал, ашиг, франчайз, дархан эрх, эсхүл эрх ямбыг хэрэгжүүлэх

Оролцогч аль нэг улс, эсхүл бусад улсаас гарал үүсэлтэй, эсхүл эдгээр улсад гаргах бүтээгдэхүүнд худалдаатай холбоотойгоор аль нэг Оролцогч улсаас олгосон аливаа давуу тал, ашиг, франчайз, дархан эрх, эсхүл эрх ямбыг Оролцогч бусад улсаас гарал үүсэлтэй, эсхүл эдгээр улсад гаргах ижил төрлийн бараа, бүтээгдэхүүнд ямар нэгэн болзолгүйгээр нэн даруй олгоно.

14 дүгээр зүйл

Хөнгөлөлтөд үл хамаарах

13 дугаар зүйлийн заалт нь Оролцогч улсаас олгож байгаа дараах хөнгөлөлтөд үйлчлэхгүй. Үүнд:

- a. Хоёр талт худалдааны хэлэлцээрээр Оролцогч бусад улс болон гуравдагч улсад олгосон хөнгөлөлт;
- b. Хөгжиж буй бусад улсад энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө онцгойлон олгосон хөнгөлөлт;
- c. Энэхүү хэлэлцээрийн 7 дугаар зүйлд заасан нэн буурай хөгжилтэй Оролцогч улсад олгосон хөнгөлөлт;
- d. Эдийн засгийн хөгжил нь харьцангуй сул гэж Оролцогч улсуудын үзсэн Оролцогч бусад улсад олгож байгаа харилцан адил бус, нэг талын хөнгөлөлт. Байнгын хороо нь эдийн засаг нь харьцангуй сул хөгжилтэй улсын бүлэгт ямар Оролцогч улсыг хамруулахаа тухай бүр шийдвэрлэнэ;
- e. Оролцогч улстай эдийн засгийн интеграцчилалын бүлэг байгуулан ажиллаж байгаа Оролцогч бусад улс, мөн/эсхүл АНДЭЗНК-ын хөгжиж буй бусад улсад олгосон хөнгөлөлт;
- f. 16 дугаар зүйлд заасны дагуу Оролцогч улстай үйлдвэрлэлийн салбарт хамтын ажиллагааны хэлэлцээртэй, эсхүл үйлдвэрлэлийн бусад салбарт хамтарсан үйлдвэртэй Оролцогч бусад улс болон хөгжиж буй улсад олгосон хөнгөлөлт;

Дээрх үл хамаарах нөхцөлийг үл харгалзан Оролцогч улс бүр гуравдагч улстай байгуулсан хэлэлцээрийн заалтыг энэхүү хэлэлцээрийн заалтад нийцүүлэх шаардлагатай алхмыг боломжийн хүрээнд хийнэ.

15 дугаар зүйл

Нэн буурай хөгжилтэй оролцогч улсыг онцгойлон анхаарах тухай

Оролцогч бусад улстай хийх худалдааг өргөжүүлэх, энэхүү хэлэлцээрийн үр ашгийг хүртэх чиглэлээр техникийн туслалцаа авах, хамтран ажиллах тухай Нэн буурай хөгжилтэй оролцогч улсын хүсэлтийг Оролцогч улсууд тусгайлан авч үзнэ.

16 дугаар зүйл

Тарифын болон тарифын бус онцгой хөнгөлөлт үзүүлэх

Оролцогч зарим, эсхүл бүх улсын хооронд, эсхүл АНДЭЗНК-ын хөгжиж буй гишүүн бусад улсын оролцсон үйлдвэрийн салбар дахь хамтын ажиллагааны хэлэлцээр болон бусад салбарын хамтарсан үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнд дээрх хэлэлцээр болон хамтын ажиллагаанд оролцогч улсыг дэмжих зорилгоор тариф болон тарифын бус тусгай хөнгөлөлт үзүүлэх асуудлыг судалж үзэхээр тохиролцов. Ийм хэлэлцээрийн болон хамтарсан үйлдвэрийн заалтыг протоколд тусгах бөгөөд Байнгын хороо тэдгээрийг энэхүү хэлэлцээртэй нийцэж буй тухай зарласны дараа Оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр болно.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ЗӨВЛӨГӨӨН**

17 дугаар зүйл

Хөнгөлөлтийг түдгэлзүүлэх

- (i) Хэрэв энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлсний дүнд Оролцогч улсын Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтад багтсан Оролцогч нөгөө улс, эсхүл Оролцогч бусад улсын нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй тодорхой бүтээгдэхүүний импорт нь импортлогч Оролцогч улсын шууд өрсөлдөхүйц бүтээгдэхүүн, эсхүл түүнтэй адилтгах бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дотоодын үйлдвэрт ноцтой хохирол учруулах, эсхүл учруулж болзошгүй тохиолдолд импортлогч Оролцогч улс нь Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтад орсон тухайн бүтээгдэхүүний хөнгөлөлтийг тухайн бүтээгдэхүүний хувьд түр хугацаанд, алагчлалгүйгээр түдгэлзүүлж болох бөгөөд үүний зэрэгцээ Байнгын хороонд даруй мэдээлж, холбогдох Оролцогч бусад улстай тухайн нөхцөл байдлыг засах тохиролцоонд хүрэхээр зөвлөлдөнө. Зөвлөгөөний явцын талаар Байнгын хороонд зохих ёсоор мэдээлж байна.
- (ii) Хэрэв холбогдох Оролцогч улсууд 90 хоногийн дотор хоорондоо тохиролцоонд хүрч чадаагүй бол Байнгын хороо нь (a) түдгэлзүүлэхийг зөвшөөрөх, эсхүл (b) хөнгөлөлтөд өөрчлөлт оруулах, эсхүл (c) ижил үнэлэгдэх өөр хөнгөлөлтөөр сольж, өөрчлөлт оруулах замаар харилцан хүлээн зөвшөөрөхүйц шийдэлд хүрэхийг зорино. Хэрэв Байнгын хороо нь тухайн өдрөөс хойш 90 хоногийн дотор хангалттай шийдвэрт хүрч чадаагүй бол түдгэлзэлд өртсөн Оролцогч улс (улсууд) нь хөнгөлөлттэй тэнцүү хэмжээний хамгаалалтын арга хэмжээ авсан Оролцогч улсын худалдаанд хамгаалалтын түр арга хэмжээг чөлөөтэй авч болно. Ингэхдээ харилцан хүлээн зөвшөөрөхүйц шийдвэрт хүрэхийн тулд цаашид хэлэлцээ хийх тухай Байнгын хороонд мэдэгдэх ёстой бөгөөд Байнгын хороо тухайн мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш 90 хоногийн дотор гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар эцсийн шийдвэрийг батална.
- (iii) Хамгаалалтын арга хэмжээг хууль ёсны дагуу авч хэрэгжүүлэх угтвар нөхцөл болон нөхцөл байдал нь ДХБ-ын Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээрт заасантай аль болох адил байна.

*18 дугаар зүйл***Төлбөрийн тэнцлийн хязгаарлалт**

- (i) Энэхүү хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн заалтыг үл харгалзан, түүнчлэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа олон улсын хэмжээнд хүлээсэн үүргийг хөндөлгүйгээр, Оролцогч улс өөрийн төлбөрийн тэнцлийг хамгаалах зорилгоор импортын хязгаарлалт тогтоох шаардлагатай гэж үзвэл хязгаарлалт тогтоож болох бөгөөд ингэхдээ өөрийн Үндэсний хөнгөлөлтийн жагсаалт дахь хөнгөлөлтийн хэмжээг хамгаалахыг эрмэлзэнэ. Харин Оролцогч улс нь Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтаа орсон бараа, бүтээгдэхүүнд ийм хязгаарлалт тогтоовол уг хязгаарлалт нь түр хугацаанд, алагчлалгүй үйлчлэх бөгөөд хэлэлцээрийн 19 болон 20 дугаар зүйлд заасан журмын дагуу харилцан ашигтай шийдэлд хүрэх зорилгоор хэлэлцээ хийх саналаа Байнгын хороонд нэн даруй мэдэгдэнэ. Зөвлөгөөний журмаас үл хамааран Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтад орсон бараа, бүтээгдэхүүнд төлбөрийн тэнцлийг хамгаалах хязгаарлалт тогтоож байгаа Оролцогч улсууд нь төлбөрийн тэнцлээ сайжрах тутам хязгаарлалтаа аажмаар багасгах бөгөөд хязгаарлалтыг хадгалах үндэслэлгүй болсон үед хязгаарлалтыг арилгах ёстой.
- (ii) Төлбөрийн тэнцлийн хамгаалалтын арга хэмжээг хуулийн дагуу хэрэгжүүлэх угтвар нөхцөл, нөхцөл байдал нь ДХБ-ын 1994 оны ТХЕХ-ийн Төлбөрийн тэнцэлтэй холбогдсон заалтын тухай харилцан ойлголцох баримт бичигт заасантай аль болох адил байна.

*19 дүгээр зүйл***Худалдааны давуу бус байдлыг арилгах арга хэмжээ**

Энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтээс үүдэн аль нэг Оролцогч улс болон бусад бүх Оролцогч улс хоорондын худалдаанд үлэмж хэмжээний болон байнгын давуу бус байдал үүссэн тохиолдолд тэдгээр Оролцогч улс нь өртсөн Оролцогч улсын хүсэлтээр түүний мэдэгдэл, эсхүл хүсэлтийг нааштай авч үзэх ёстой. Байнгын хороо нь энэхүү давуу бус байдлыг арилгахад шаардагдах алхмыг хийх зорилгоор олон талт худалдааг цаашид өргөтгөхөд чиглэсэн нэмэлт хөнгөлөлт олгох зэрэг тохиромжтой арга хэмжээ авах зорилго бүхий зөвлөгөөн хийх хангалттай боломж олгоно.

*20 дугаар зүйл***Гэрээний үүргийг үл биелүүлэх**

Хэрэв Оролцогч улс нь Оролцогч нөгөө улсыг энэхүү хэлэлцээрийн аль нэг заалтыг дагаж мөрдөхгүй, ийнхүү мөрдөхгүй байгаа нь тухайн Оролцогч улстай хийж буй худалдаанд сөргөөр нөлөөлж байна гэж үзвэл түүнд албан ёсоор мэдэгдэл өгч болох бөгөөд уг Оролцогч улс мэдэгдлийг зохих ёсоор авч үзнэ. Хэрэв ийм мэдэгдэл өгсөн өдрөөс хойш 120 хоногийн дотор холбогдох Оролцогч улс хооронд хангалттай зохицуулалт хийгдээгүй бол уг асуудлыг Байнгын хороонд шилжүүлж болох бөгөөд Хороо зохимжтой гэж үзсэн зөвлөмжийг аль нэг Оролцогч улсад хандан гаргаж болно. Хэрэв тухайн Оролцогч улс Байнгын хорооны зөвлөмжийг биелүүлээгүй бол Хороо шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээний үүргийг биелүүлэхгүй байгаа улсын хувьд хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргийн хэрэгжилтийг түдгэлзүүлэх эрхийг аливаа Оролцогч улсад олгож болно.

21 дүгээр зүйл

Маргаан шийдвэрлэх

Энэхүү хэлэлцээр, эсхүл түүний хүрээнд батлагдсан аливаа баримт бичгийн заалтыг тайлбарлах болон хэрэгжүүлэхтэй холбогдон Оролцогч улс хооронд үүсэж болох аливаа маргааныг холбогдогч талууд нөхөрсгөөр тохиролцон шийдвэрлэнэ. Оролцогч улсууд нь хоорондын маргаанаа шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Байнгын хороогоор шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ. Байнгын хороо асуудлыг хянан үзээд маргааныг хүлээн авсан өдрөөс хойш 120 хоногийн дотор зөвлөмж гаргана. Байнгын хороо энэхүү зорилгоор холбогдох дүрмийг батална.

ТАВДУГААР БҮЛЭГ
БАЙНГЫН ХОРОО БОЛОН ХЭЛЭЛЦЭЭРИЙН УДИРДЛАГА

22 дугаар зүйл

Байнгын хороо

Энэхүү хэлэлцээрт Оролцогч улсуудын төлөөлөгчөөс бүрдсэн Байнгын хороо (цаашид “Хороо” гэх) нь жилд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөгөөн зохион байгуулах, шаардлагатай үед зөвлөмж болон шийдвэр гаргах үүрэгтэй бөгөөд ерөнхийдөө энэхүү хэлэлцээрийн зорилго, заалтын зохих ёсны хэрэгжилтийг хангахад шаардагдах аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

23 дугаар зүйл

Сайд нарын зөвлөл

Оролцогч улсууд энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт тавих, удирдан зохицуулах зорилгоор Оролцогч улс бүрийн холбогдох эдийн засгийн яамны нэг сайдаас бүрдсэн сайд нарын түвшний Зөвлөлийг байгуулна. Зөвлөл нь 2 жил тутамд нэг удаа, эсхүл шаардлагатай тохиолдолд хуралдана. Хороо нь Сайд нарын зөвлөлийг үүргээ гүйцэтгэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

24 дүгээр зүйл

Шийдвэр гаргах

Хороо нь шийдвэрийг зөвшилцлөөр гаргах дадлыг хэрэгжүүлэхийг эрмэлзэх бөгөөд боломжит бүх тохиолдолд хэрэгжүүлнэ. Шаардлага гарвал Хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах үйл ажиллагааны ийм журмыг Оролцогч улсуудын гуравны хоёроос доошгүйг нь байлцуулан, санал хураалтад оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар батална. Хороо нь энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар гуравдагч улс болон олон улсын байгууллагатай холбогдох, техникийн зөвлөгөө авах, аль нэг улсын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах хүсэлт гаргаж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
ХЯНАХ, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

25 дугаар зүйл

Хэлэлцээрийг хянах

- (i) Хороо нь хуралдаан бүрд энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад гарсан ахицыг 2 болон 3 дугаар зүйлд заасан зорилго, зарчмыг харгалзан үзсэний үндсэн дээр дүгнэн үзнэ.



- (ii) Энэхүү хэлэлцээрийн ашиг тусыг Оролцогч бүх улс 2 дугаар бүлэгт тусгагдсан Худалдааг либералчлах хөтөлбөрт оруулсан хувь нэмэртээ нийцүүлэн, харилцан ашигтай байдлаар хүртэх боломжийг хангах зорилгоор Хороо нь Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтад шаардлагатай залруулга, сайжруулалт хийх үүднээс харилцан хийгдэж буй худалдааг жилд нэгээс доошгүй удаа хянана.
- (iii) Хороо нь АНДЭЗНК-ын хөгжиж буй гишүүн улсуудын дунд худалдааг өргөжүүлэх зорилгыг ахиулах арга замыг тодорхойлох зорилгоор гурван жил тутам ерөнхий хяналтын ажлыг зохион байгуулна.

26 дугаар зүйл

Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах

Өөрчлөлт оруулах тухай заалт энэхүү хэлэлцээрийн аль нэг хэсэгт орсноос бусад тохиолдолд энэхүү хэлэлцээрийн бүх заалтыг хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах замаар өөрчилж болно. Энэхүү хэлэлцээрийн 2, 3 дугаар бүлэг болон 26 дугаар зүйлийн заалтад оруулах нэмэлт, өөрчлөлт нь Оролцогч бүх улс хүлээн зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болно. Хороо нь бусад бүх нэмэлт, өөрчлөлтийг хүчин төгөлдөр болгох асуудлыг зөвшилцлийн үндсэн дээр шийдвэрлэх боломжит бүх арга хэмжээг авна. Хэрэв зөвшилцөлд хүрээгүй бол нэмэлт, өөрчлөлт нь оролцогч улсуудын гуравны хоёр нь хүлээн зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болно.

27 дугаар зүйл

Хөнгөлөлт үйлчлэх хугацаа

4 дүгээр бүлэгт дурдсан тусгай нөхцөлөөс бусад тохиолдолд Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтад орсон хөнгөлөлт нь хүчин төгөлдөр болсон өдрөөсөө эхлэн доод тал нь 3 жилийн хугацаатай байна. Энэ хугацаа дуусах үед хөнгөлөлт өөрчлөгдсөн, эсхүл цуцлагдсан тохиолдолд тухайн Оролцогч улсууд нь хөнгөлөлтийн ерөнхий түвшинг тогтоох зөвлөгөөн хийх бөгөөд энэхүү түвшин нь тэдний хоорондын худалдааны хувьд өөрчлөгдсөн, эсхүл цуцлагдсан хөнгөлөлттэй адил тааламжтай байна.

28 дугаар зүйл

Хөнгөлөлтийг өөрчлөх

Хөнгөлөлтийг 4 дүгээр бүлгийн заалтын дагуу цуцалсан буюу өөрчилсөн тохиолдолд тухайн Оролцогч улс түүнийг наад зах нь өмнөх хөнгөлөлттэй ижил үнэлгээ бүхий хөнгөлөлтөөр орлуулна.

29 дүгээр зүйл

Хөнгөлөлт болон оролцоог дэмжих

Хороо нь Хөнгөлөлтийн үндэсний жагсаалтад нэмэлт оруулах болон Оролцогч улсын тоог нэмэгдүүлэх хэлэлцээг байнга дэмжих бөгөөд 25 дугаар зүйлийн дагуу жил бүр хийгдэх худалдааг хянан үзэх ажиллагаа, эсхүл шаардлагатай гэж үзсэн үед хэлэлцээ хийхийг дэмжинэ.

**ДОЛДУГААР БҮЛЭГ
НЭГДЭН ОРОХ БОЛОН ХЭЛЭЛЦЭЭРЭЭС ГАРАХ**

30 дугаар зүйл

Хэлэлцээрт нэгдэн орох

- (i) Энэхүү хэлэлцээр нь хүчин төгөлдөр болсноосоо хойш АНДЭЗНК-ын хөгжиж буй аль ч гишүүн улсын хувьд нэгдэн ороход нээлттэй байна.
- (ii) Хороо нь АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн даргаар дамжуулан уг хэлэлцээрт нэгдэн орох хүсэлтээ илэрхийлсэн улсаас мэдэгдэл хүлээж авсны дараа тус улсын одоогийн болон ирээдүйн хөгжил, худалдааны хэрэгцээ, шаардлага, түүнчлэн харилцан ашигтай байх зарчимд нийцүүлэн, хүсэлт гаргасан улсыг хэлэлцээрт нэгдэн ороход шаардлагатай арга хэмжээг авна.
- (iii) Хүсэлт гаргагч улс нь Оролцогч улсуудын мөрдөж буй хөнгөлөлтийн жагсаалттай солилцох өөрийн улсын хөнгөлөлтийн жагсаалтыг санал болгох бөгөөд өөрөөр шийдээгүй бол хүсэлтийн-жагсаалт гаргах замаар болон өөр бусад хэлбэрээр Оролцогч улсуудаас нэмэлт хөнгөлөлт авах хүсэлт гаргаж болохгүй.
- (iv) Зохих ёсоор хэлэлцээний дараа бүрэн зөвшилцөлд хүрвэл хүсэлт гаргагч улс энэхүү хэлэлцээрт нэгдэн орж болно. Зөвшилцөлд хүрээгүй бол Оролцогч улсуудын гуравны хоёроос доошгүйн дэмжлэг авснаар хүсэлт гаргасан улс хэлэлцээрт нэгдэн орж болно. Оролцогч улсуудын аль нэг нь нэгдэхийг эсэргүүцсэн тохиолдолд эсэргүүцсэн улс болон нэгдэж буй улс хооронд энэхүү хэлэлцээрийн зохицуулалт үйлчлэхгүй.
- (v) Энэхүү хэлэлцээр нь шалгуур хангасан нэгдэн орж буй улсын хувьд хэлэлцээрт нэгдэн орох батламж жуух бичиг, Үндэсний хөнгөлөлтийн жагсаалт болон захиргааны холбогдох мэдэгдлийг АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн даргад хадгалуулсан өдөр хүчин төгөлдөр болно.
- (vi) Энэ зүйлийн хүрээнд захиргааны холбогдох мэдэгдэл гэснийг нэгдэн орж буй улсын энэхүү хэлэлцээрээр хүлээсэн үүргийг бодитоор хэрэгжүүлж эхлэхэд шаардагдах гаалийн мэдэгдэл зэрэг Засгийн газрын мэдэгдлийг ойлгоно.

31 дүгээр зүйл

**Нэгдэн орсон, соёрхон баталсан болон
хүчин төгөлдөр болсон тухай мэдэгдэх**

АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Оролцогч улсууд болон АНДЭЗНК-ын хөгжиж буй бусад гишүүн улсуудад (а) энэхүү хэлэлцээрт нэгдэн орсон болон соёрхон баталсан тухай болон (b) энэхүү хэлэлцээр нь шинэ Оролцогч улсын хувьд хүчин төгөлдөр үйлчилж эхлэх огноог мэдэгдэнэ.

32 дугаар зүйл

Хэлэлцээрээс гарах

Аливаа Оролцогч улс энэхүү хэлэлцээрээс гарч болох бөгөөд энэ тухай мэдэгдлээ АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн даргаар дамжуулан Оролцогч улсуудад бичгээр хүргүүлсэн өдрөөс хойш 6 сарын дараа тус хэлэлцээрээс гарсан гэж үзнэ. Энэхүү хэлэлцээрээс гарсан Оролцогч улсын эрх, үүрэг нь тэр өдрөөс эхлэн цуцлагдана. Тэр өдрөөс хойш Оролцогч улсууд хэлэлцээрээс гарч буй улстай хамтран гарч буй улсаас Оролцогч бусад улсад олгож байсан, эсхүл бусад Оролцогч улсаас гарч буй улсад олгож байсан хөнгөлөлтийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцлах эсэхийг шийдвэрлэнэ.

**НАЙМДУГААР БҮЛЭГ
БУСАД, ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ***33 дугаар зүйл***Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах**

29 дүгээр зүйлийн дагуу 1 дүгээр хавсралтын нэмэлт, өөрчлөлтөд дараах зүйл багтана. Үүнд:

- (a) Оролцогч улсуудын Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтад орсон бараа, бүтээгдэхүүний тариф, хилийн төлбөр, хураамж, тарифын бус арга хэмжээг бууруулах;
- (b) Оролцогч улсуудын Үндэсний хөнгөлөлтийн жагсаалтад одоогоор ороогүй бараа, бүтээгдэхүүний тариф, хилийн төлбөр, хураамж, тарифын бус арга хэмжээг бууруулах;
- (c) Шинээр нэгдэн орж буй улсуудын Хөнгөлөлтийн үндэсний жагсаалтад орсон бараа, бүтээгдэхүүний тариф, хилийн төлбөр, хураамж, тарифын бус арга хэмжээг бууруулах.

*34 дүгээр зүйл***Үндэсний хөнгөлөлтийн жагсаалт хүчин төгөлдөр болох**

Оролцогч улсын санал бүхий мэдэгдлийг Хороо хүлээн авч, гуравны хоёрын саналаар тухайн санал болгож буй нэмэлт, өөрчлөлтийг энэхүү хэлэлцээрийн зорилготой нийцэж байгаа тухай мэдэгдсэн өдрөөс хойш 30 хоногийн дараа 1 дүгээр хавсралтад оруулах нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болно. Оролцогч улсын Засгийн газар нь энэхүү заалтыг мөрдөхөд шаардагдах дотоодын захиргааны арга хэмжээг авах үүрэг хүлээнэ. Нэгдэж буй улсын Үндэсний хөнгөлөлтийн жагсаалт нь нэгдэн орсон тухай холбогдох баримт бичгийг АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн даргад хадгалуулснаас хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

*35 дугаар зүйл***Онцгой нөхцөл**

Энэхүү хэлэлцээрийн аль ч заалт Оролцогч улс өөрийн үндэсний аюулгүй байдал, нийгмийн ёс суртахууныг хамгаалах, хүн, амьтан, ургамлын эрүүл мэндийг хамгаалах болон урлагийн бүтээл, түүх, археологийн үнэт зүйлсийг хамгаалахад шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд саад болохгүй.

*36 дугаар зүйл***Хэлэлцээрийг үл хэрэглэх**

Оролцогч улс хооронд шууд хэлэлцээ хийгээгүй бөгөөд тэдгээрийн аль нэг нь гарын үсэг зурах, нэгдэн орох, эсхүл соёрхон баталсан тухай батламж жуух бичгээ хадгалуулах үедээ тус хэлэлцээрийг харилцан хэрэглэхээр тохиролцоогүй бол энэхүү хэлэлцээр нь тэдгээр Оролцогч улс хооронд үйлчлэхгүй.

*37 дугаар зүйл***Тайлбар хийх**

36 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурах, эсхүл соёрхон батлах, эсхүл нэгдэн орох үед тайлбар хийж болохгүй.

38 дугаар зүйл

Эх хадгалах

Энэхүү хэлэлцээрийн эх хувь болон хэлэлцээрийн нэмэлт, өөрчлөлтийг АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга хадгалах бөгөөд тэрээр Оролцогч улс бүрд хэлэлцээрийн баталгаат хуулбарыг хүргүүлнэ.

39 дүгээр зүйл

Хэлэлцээрийг бүртгэх

Энэхүү хэлэлцээрийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн 102 дугаар зүйлийн дагуу бүртгүүлнэ.

40 дүгээр зүйл

Хэлэлцээрийн нэр

Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Хөгжиж буй гишүүн улсын худалдааны хэлэлцээний анхны хэлэлцээр буюу Бангкокийн хэлэлцээр гэж нэрлэж байсан энэхүү хэлэлцээрийг үүнээс хойш Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр гэж нэрлэнэ.

Дээрхийг нотолж, анхдагч гарын үсэг зурсан улсын дор дурдсан бүрэн эрхт төлөөлөгчид тус тусын Засгийн газрыг төлөөлөн энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав. Хоёр мянга таван оны арван нэгдүгээр сарын хоёрны энэ өдөр Бээжин хотноо англи хэлээр нэг хувь үйлдэв.

Хавсралт I

Үндэсний хөнгөлөлтийн жагсаалт

- **1. Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс**
 - 1.1 Үндсэн хөнгөлөлт
 - 1.2 Тусгай хөнгөлөлт
- **2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс**
 - 2.1 Үндсэн хөнгөлөлт
 - 2.2 Тусгай хөнгөлөлт
- **3. Бүгд Найрамдах Энэтхэг Улс**
 - 3.1 Үндсэн хөнгөлөлт
 - 3.2 Тусгай хөнгөлөлт
- **4. Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс**
 - 4.1 Үндсэн хөнгөлөлт
- **5. Монгол Улс**
 - 5.1 Үндсэн хөнгөлөлт
- **6. Бүгд Найрамдах Солонгос Улс**
 - 6.1 Хөнгөлөлтийн үндэсний жагсаалт
- **7. Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улс**
 - 7.1 Үндсэн хөнгөлөлт
 - 7.2 Тусгай хөнгөлөлт



1. БҮГД НАЙРАМДАХ БАНГЛАДЕШ АРД УЛС
1.1 ХӨНГӨЛӨЛТИЙН ҮНДЭСНИЙ ЖАГСААЛТ (БТКУС 2017)

(АНДХХ-ийн 4 дэх шатны хэлэлцээ)

д/д	БТКУС 2017	Барааны бичиглэл	Хөнгөлөлт-тэй тарифын хэмжээ (%)
1	0501.00.00	Хүний үс болон хаягдал, боловсруулагүй	20
2	0504.00.00	Шинэ, хөргөсөн, хөлдөөсөн, давсны уусмалд давсалсан, хатаасан, утсан малын өлөн гэдэс, давсаг болон ходоод (загас орохгүй)	20
3	0506.10.00	Хүчлээр боловсруулсан оссейн болон яс	20
4	0510.00.10	Булчирхай (өнчин тархи орно)	20
5	0510.00.90	Бусад	20
6	0801.11.10	Наргилын самар: шинэ, эсхүл хатаасан (боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан)	60
7	0801.11.90	Наргилын самар: шинэ, эсхүл хатаасан (боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан нь орохгүй)	60
8	0801.12.10	Дотор хальс (эндокарп)-тай наргилын самар (боодолтой / 2.5 кг-аар лаазалсан)	70
9	0801.12.90	Дотор хальс (эндокарп)-тай наргилын самар (боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан нь орохгүй)	70
10	0801.19.10	Наргил модны самар (хатаагаагүй), шинэ, эсхүл хатаасан (боодолтой / 2.5кг хүртэлх хэмжээгээр лаазалсан)	70
11	0801.19.90	Наргил модны самар (хатаагаагүй), шинэ, эсхүл хатаасан (боодолтой / 2.5кг хүртэлх хэмжээгээр лаазалсан нь орохгүй)	70
12	0904.11.10	Чинжүү, бутлаагүй, нунтаглаагүй (боодолтой/ 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан)	10
13	0904.11.90	Чинжүү, бутлаагүй, нунтаглаагүй (боодолтой/ 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан нь орохгүй)	10
14	0908.11.10	Задь, бутлаагүй, эсхүл нунтаглаагүй (боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан)	10
15	0908.11.90	Задь, бутлаагүй, эсхүл нунтаглаагүй (боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан нь орохгүй)	10
16	0908.12.10	Задь, буталсан, эсхүл нунтагласан, (боодолтой / 2.5 кг-аар лаазалсан)	10
17	0908.12.90	Задь, буталсан, эсхүл нунтагласан, (боодолтой / 2.5 кг-аар лаазалсан орохгүй)	10
18	0908.21.10	Задийн бүрхүүл, бутлаагүй, эсхүл нунтаглаагүй (боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан)	10
19	0908.21.90	Задийн бүрхүүл, бутлаагүй, эсхүл нунтаглаагүй (боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан нь орохгүй)	10
20	0908.22.10	Задийн бүрхүүл, буталсан, эсхүл нунтагласан (боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан)	10
21	0908.22.90	Задийн бүрхүүл, буталсан, эсхүл нунтагласан (боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан нь орохгүй)	10
22	0908.31.10	Кардамон, бутлаагүй, эсхүл нунтаглаагүй (боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан)	10
23	0908.31.90	Кардамон, бутлаагүй, эсхүл нунтаглаагүй (боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан нь орохгүй)	10



24	0908.32.10	Кардамон, буталсан, эсхүл нунтагласан (боодолтой/2.5 кг-аар лаазалсан)	10
25	0908.32.90	Кардамон, буталсан, эсхүл нунтагласан (боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан нь орохгүй)	10
26	1001.11.10	Хатуу эрдэнэ шишийн үр, боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
27	1001.11.90	Хатуу эрдэнэ шишийн үр (боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан нь орохгүй)	20
28	1001.19.10	Үрнээс бусад хатуу эрдэнэ шиш, боодолтой/ 2.5кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
29	1001.19.90	Үрнээс бусад хатуу эрдэнэ шиш, (боодолтой/ 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан нь орохгүй)	20
30	1007.10.10	Үр тарианы улаан буурцагны үр (боодолтой, 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан)	20
31	1007.10.90	Үр тарианы улаан буурцагны үр (боодолтой, 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан нь орохгүй)	20
32	1007.90.10	Үр тарианы улаан буурцаг, үрнээс бусад (боодолтой, 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан)	20
33	1007.90.90	Үр тарианы улаан буурцаг, үрнээс бусад (боодолтой, 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан нь орохгүй)	20
34	1008.21.10	Шар будааны үр, боодолтой/ 2.5 хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
35	1008.21.90	Шар будааны үр, боодолтой/ 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан нь орохгүй	20
36	1008.29.10	Шар будаа, үрнээс бусад (боодолтой/ 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан)	20
37	1008.29.90	Шар будаа, үрнээс бусад (боодолтой/ 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан нь орохгүй)	20
38	1008.30.10	Канари үр (боодолтой/ 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
39	1008.40.10	Фонио (дигитариа) боодолтой/ 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
40	1008.50.10	Чиноа (Ченеподиум чиноа), боодолтой/ 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
41	1008.60.10	Арван улаан буудайг хольж сонгон үржүүлж гаргасан тариа, боодолтой / 2.5кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
42	1008.90.10	Бусад үр тариа, боодолтой / 2.5кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
43	1103.20.00	Булцуу	20
44	1104.23.00	Бусад боловсруулсан үр (жишээ нь: хальстай, хальсалсан, зүссэн, эсхүл нунтагласан) эрдэнэшиш, өөр хэсэгт дурдагдаагүй	20
45	1202.30.10	Газрын самарны үр, хуураагүй, эсхүл болгоогүй, боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
46	1202.42.10	Бусад газрын самар, ястай боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
47	1203.00.00	Наргил модны самрын зөөлөн эд	20
48	1210.10.10	Нарсны боргоцой, шинэ, эсхүл хатаасан, үрлэн хэлбэртэй бус бутлаагүй, нунтаглаагүй боодолтой / 2.5кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
49	1211.30.10	Дал модны навч, боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
50	1211.50.10	Зээргэнэ, боодолтой / 2.5кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
51	1211.90.11	Үнэртэнд хэрэглэгддэг Агар зэрэг ургамал болон тэдгээрийн зүйл, боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20



52	1211.90.21	Ургамал болон тэдгээрийн зүйл, эмзүйн зориулалттай, боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
53	1212.92.10	Хуайс модны шош (арцны ногоон мод) боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
54	1212.93.10	Чихрийн нишингэ, боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
55	1212.94.10	Цикори үндэс, боодолтой / 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
56	1212.99.10	Хүний хэрэгцээнд зориулсан хүнсний ногоо, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, өөр бусад хэсэгт заагаагүй, эсхүл ороогүй, боодолтой / 2.5кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
57	1213.00.10	Амуу тарианы сүрэл болон хивэг, бэлтгээгүй, огтолж тайрсан, эсхүл тайраагүй, үрлэн хэлбэрт шахсан, боодолтой/ 2.5 кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
58	1214.10.10	Царгасны (alfalfa) буталмал болон хорголж, боодолтой / 2.5кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
59	1214.90.10	Царгасны (alfalfa) буталмал болон хорголжоос бусад малын тэжээлийн бүтээгдэхүүн, боодолтой, 2.5кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
60	1302.12.00	Ургамлын шүүс болон ханд	20
61	1404.20.10	Хөвөгийн ноолуур, боодолтой/ 2.5кг хүртэлх хэмжээгээр лаазалсан	20
62	1508.10.00	Боловсроогүй газрын самрын тос	20
63	1512.11.00	Боловсроогүй наранцэцгийн үр, эсхүл	20
64	1512.21.00	Боловсроогүй хөвөнгийн ургамлын үрийн тос, госсипол	20
65	1512.29.00	Шүүн цэвэршүүлсэн хөвөнгийн ургамлын үрийн тос болон түүний хэсэг, химийн аргаар өөрчлөөгүй	20
66	1513.11.00	Боловсроогүй наргил модны самрын тос	30
67	1513.19.00	Наргил модны самрын тос, боловсруулаагүй хэсэг орохгүй, шүүж цэвэршүүлсэн, эсхүл цэвэршүүлээгүй, гэхдэ химийн аргаар өөрчлөөгүй	20
68	1514.11.00	Боловсруулаагүй рапс, эсхүл боловсруулаагүй рапсын тос	20
69	1515.21.00	Боловсроогүй эрдэнэ шишийн тос	20
70	1801.00.00	Какаоны шош, бүтнээрээ, эсхүл хагалсан, түүхий, эсхүл хуурсан	20
71	1802.00.00	Какаоны хальс болон бусад хаягдал	20
72	1803.10.00	Какаоны түрхлэг, тосноос нь салгасан	20
73	1803.20.00	Какаоны түрхлэг, бүхлээр нь, эсхүл хэсэгчилж тосноос нь салгасан	20
74	2401.10.00	Гол судлыг нь салгаагүй түүхий тамхи	50
75	2504.10.00	Байгалийн бал чулуу, нунтаг болон ширхэг хэлбэр орно	10
76	2504.90.00	Байгалийн бал чулуу, нунтаг болон ширхэг хэлбэр орохгүй	20
77	2505.10.00	Цахиурлаг элс болон кварцан элс	10
78	2505.90.00	Байгалийн элс, өнгө оруулаагүй (цахиур элс, кварц элс болон метал агуулсан элс орохгүй)	10
79	2506.20.00	Кварцит	20
80	2508.50.00	Андалусит, кианит болон силлиманит	20
81	2508.70.00	Шамот, эсхүл газрын динас	20
82	2518.20.00	Бүрэн шатаасан болон жигнэсэн доломит	20
83	2518.30.00	Доломит (балбар) дагтаршуулсан хольмог	20



84	2528.00.00	Байгалын борын хүчлийн давс болон түүний баяжмал (шатаасан, эсхүл шатаагаагүй)	20
85	2529.22.00	97%-иас дээш кальцийн фторт нэгдэл агуулсан хайлуур жонш	20
86	2529.30.00	Цанар (лейцит); мана (нефелин) ба манат таланс (нефелин-сиенит)	20
87	2601.11.00	Бөөмнөрөөгүй төмрийн хүдэр болон баяжмал, шатаасан төмөр пиритээс бусад	20
88	2601.12.00	Бөөмнөрсөн төмрийн хүдэр болон баяжмал, шатаасан төмөр пиритээс бусад	20
89	2601.20.00	Шатаасан төмөр пирит	20
90	2602.00.00	Мангааны хүдэр болон баяжмал, төмөр агуулсан мангааны хүдэр болон 20% болон түүнээс их мангааны баяжмал, хуурай жингээр тооцоолсон	20
91	2603.00.00	Зэсийн хүдэр болон баяжмал	20
92	2604.00.00	Никель хүдэр болон баяжмал	60
93	2605.00.00	Кобальт хүдэр болон баяжмал	60
94	2606.00.00	Хөнгөн цагааны хүдэр болон баяжмал	20
95	2607.00.00	Хар тугалганы хүдэр болон баяжмал	20
96	2608.00.00	Цайрын хүдэр болон баяжмал	20
97	2609.00.00	Тугалганы хүдэр болон баяжмал	60
98	2610.00.00	Хромын хүдэр болон баяжмал	20
99	2611.00.00	Вольфрамын хүдэр болон баяжмал	60
100	2612.10.00	Ураны төмөрлөг болон баяжмал	60
101	2612.20.00	Торийн хүдэр болон баяжмал	60
102	2613.10.00	Шатаасан молибдений хүдэр болон баяжмал	60
103	2613.90.00	Молибдений хүдэр болон баяжмал, шатаасан нь орохгүй	20
104	2614.00.00	Титаны хүдэр болон баяжмал	20
105	2615.10.00	Цирконий хүдэр болон баяжмал	20
106	2615.90.00	Ниобиум, Тантал болон ванадын хүдэр болон баяжмалууд	60
107	2616.10.00	Мөнгөний хүдэр болон баяжмал	60
108	2616.90.00	Үнэт металлын хүдэр болон баяжмал (мөнгө орохгүй)	60
109	2617.10.00	Сурьма-н хүдэр болон баяжмал	20
110	2619.00.00	Нүүрсний хог хаягдал (буталсан хог хаягдалаас бусад) өнгөр болон бусад	20
111	2620.11.00	Техникийн цинк	60
112	2620.21.00	Хар тугалгатай шингэн шатахууны хаягдал болон нийлэг бус хаягдал	60
113	2620.29.00	Бусад хар тугалга агуулсан хог, үнс, шаар	60
114	2620.30.00	Зэс агуулсан бусад хог, үнс, шаар	60
115	2620.60.00	Хүнцэл, мөнгөн ус, талли, эсхүл тэдгээрийн хольцыг агуулсан, хүнцэл, эсхүл тэдгээр металлыг гарган авах, эсхүл тэдгээрийн химийн нэгдлийг үйлдвэрлэхэд хэрэглэгддэг шаараг үнс болон үлдэгдэл	60
116	2620.91.00	Антимон, берилл, кадми, хром, эсхүл тэдгээрийн нэгдэл агуулсан хог, үнс, шаар	60
117	2621.90.10	Хүрэн манжингийн молексын үлдэгдэлээс олж авсан түүхий калийн давс	20



118	2621.90.90	Бусад хог болон үнс	60
119	2702.10.00	Хүрэн нүүрс, нунтагласан, эсхүл нунтаглаагүй, гэхдээ бөөмнөрүүлээгүй	20
120	2702.20.00	Бөөмнөрсөн хүрэн нүүрс	20
121	2703.00.00	Хүлэр (хүлрийн хаягдал орно), бөөмнөрүүлсэн, эсхүл бөөмнөрүүлээгүй	20
122	2704.00.00	Чулуун нүүрс, хүрэн нүүрс болон хүлрийн бөөмнөрүүлсэн, эсхүл бөөмнөрүүлээгүй кокс болон хагас кокс; хийн зуухны нүүрс (реторт нүүрс)	10
123	2707.10.00	Бензол (бензен)	20
124	2707.20.00	Толуол	20
125	2707.40.00	Нафтален	20
126	2708.20.00	Чулуун нүүрсний давирхай, эсхүл бусад эрдэс давирхайнаас гаргаж авсан цөвийн кокс	20
127	2711.11.00	Шингэрүүлсэн байгалын хий	20
128	2711.12.00	Шингэрүүлсэн пропан	20
129	2713.11.00	Шатаагүй газрын тосны кокс	20
130	2716.00.00	Цахилгаан эрчим хүч	60
131	2801.20.00	Йодийн нэгдэл	20
132	2801.30.00	Флуорин, бромин	20
133	2803.00.00	Нүүрс (нүүрсний хөө болон нүүрсний бусад хэлбэрүүд, бусад хэсэгт заагаагүй, эсхүл ороогүй)	10
134	2805.30.00	Түүхий газрын метал, скандий болон иттрий (хольсон, эсхүл холиогүй)	20
135	2813.90.00	Метал бус хүхэрлэг нэгдэл (карбон дисульфид орохгүй) фосфор трисульфид	20
136	2816.40.00	Мөнгөн цагаан (Стронти) болон барийн оксид, гидроксид болон пероксид	20
137	2817.00.00	Цайрын оксид, цайрын исэл	10
138	2818.10.00	Хиймэл корунд, химийн аргаар тогтоогоогүй	20
139	2821.20.00	Төмрийн исэл болон усан исэл; Fe ₂ O ₃ -д тооцсоноор жингийн 70% буюу түүнээс дээш хэсэгт төмрийн исэл агуулсан шороон будаг.	20
140	2824.10.00	Хар тугалга дан исэл	30
141	2825.60.00	Германы оксид болон цирконий диоксид	20
142	2826.12.00	Хөнгөн цагааны фторт нэгдэл	20
143	2826.30.00	Натрийн гексафлуоралуминат (нийлэг криолит)	20
144	2827.41.00	Зэсийн хлорт оксид болон хлорид хэт исэл	20
145	2830.10.00	Натрийн сульфид	10
146	2831.90.00	Дитионит болон сульфоксилат (натри орохгүй)	20
147	2833.29.90	Сульфат, квасц, пероксосульфат (персульфат), бусад хэсэгт заагаагүй	20
148	2835.24.00	Калийн фосфат	20
149	2836.99.90	Бусад карнонат, пероксокарбонат (төмөр агуулсан карбонат орохгүй)	10
150	2841.69.00	Хар хүрэн марганцын хүдэр, марганцын хүчлийн давс болон марганц хүчлийн давс (калийн марганц хүчлийн давс орохгүй)	20
151	2841.80.00	Вольфрам хүчлийн давс	20

152	2843.90.10	Цисплатин, оксалиплатин, карбоплатин	20
153	2843.90.90	Үнэт металын органик бус, эсхүл органик нэгдэл, химийн аргаар тодорхойлсон, эсхүл тодорхойлоогүй, мөнгө болон алтны нэгдэл орохгүй, үнэт металын хайлш (хольц)	20
154	2901.10.00	Ацилик гидрокарбон, ханасан	15
155	2901.21.00	Этилин	30
156	2901.22.00	Пропен (пропилин)	30
157	2901.23.00	Бутен (бутелен) болон тэдгээрийн изомер	30
158	2901.24.00	Бута-1,3-диэн болон изопрен	30
159	2902.11.00	Циклогексин	30
160	2902.20.00	Бензол (бензин)	30
161	2902.30.00	Толуол	10
162	2902.41.00	о-ксилол	30
163	2902.42.00	м-ксилол	30
164	2902.43.00	п-ксилол	30
165	2902.44.00	Ксилолын изомерийн холимог	10
166	2902.50.10	НӨАТ-ийн бүртгэлтэй үйлдвэрлэгчийн импортолсон стирол	10
167	2902.50.90	НӨАТ-ийн бүртгэлтэй үйлдвэрлэгчээс бусад этгээдийн импортолсон стирол	10
168	2902.60.00	Этилбензол	30
169	2902.70.00	Кумен	30
170	2903.11.00	Хлорометан (метил хлорид) болон хлорэтан (этил хлорид)	20
171	2903.21.00	Венил хлорид (хлорэтилин)	20
172	2903.29.00	Цагираг бус ханаагүй нүүрс устөрөгчийн хлорт уламжлал, өөр газар тодорхойлоогүй	20
173	2903.31.00	Этилин дибромид (1,2 дибромэтан)	20
174	2903.76.00	Бромохлорид-флюорометан, бромотрифлюорометан болон дибромтетрафлюорэтан	20
175	2903.77.10	Трихлорфлюорометин	20
176	2903.77.20	Ди-хлоридфлюорометин	20
177	2903.77.30	Трихлоротрифлюорэтан	20
178	2903.77.40	Дихлоротитрафлюорэтан болон хлоропентафлюорэтан	20
179	2903.77.50	Зөвхөн флуорин болон хлориноор галогенжсэн бусад үүсмэл	20
180	2903.78.00	Бусад галогенжсэн үүсмэл	20
181	2903.92.00	Гексахлорбензин (клофенотан 1,1,1-трихлор-2,2,бис (п-хлорофенил этан))	20
182	2905.11.10	Метанол (метилийн спирт)	10
183	2905.11.90	Метанол (метилийн спирт)	10
184	2905.12.10	НӨАТ-ийн бүртгэлтэй бэх үйлдвэрлэгчийн импортолсон изопропил спирт	10
185	2905.12.90	НӨАТ-ийн бүртгэлтэй бэх үйлдвэрлэгчээс бусад этгээдийн импортолсон изопропил спирт	10
186	2905.13.00	Бутан-1-ол (н-бутил алкохол)	10
187	2905.14.00	Бусад бутанолууд, өөр бусад заагдаагүй	10
188	2905.16.10	НӨАТ-ийн бүртгэлтэй ортофталат үйлдвэрлэгчийн импортолсон октанол, октил спирт болон тэдгээрийн изомир	10



189	2905.16.90	НӨАТ-ийн бүртгэлтэй ортофталат үйлдвэрлэгчээс бусад этгээдийн импортолсон октанол, октил спирт болон тэдгээрийн изомир	10
190	2905.17.00	Додекан-1-ол (лаурилийн спирт), гексадекан-1-ол (цетилин спирт) болон октадекан-1-ол (стерилийн спирт)	10
191	2905.19.00	Бусад ханасан моногидрид спирт, бусад газар заагдаагүй	10
192	2905.22.00	Цагираг бус терпений спирт	10
193	2905.31.10	НӨАТ-ийн бүртгэлтэй "РЕТ" ялтас үйлдвэрлэгчийн импортолсон этилин гликол	10
194	2905.31.90	НӨАТ-ийн бүртгэлтэй "РЕТ" ялтас үйлдвэрлэгчээс бусад этгээдийн импортолсон этилин гликол	10
195	2905.32.00	Пропилин гликол (пропен-1, 2-диол)	30
196	2905.41.00	2-Этил-2 (гидроксиметил) пропен-1, 3-диол (триметилпропен)	30
197	2905.42.00	Пентаэритрол	10
198	2905.43.00	Маннитол	10
199	2905.44.00	Д-глюцитол (сорбитол)	10
21	6103.43	Эрэгтэйчүүдийн, эсхүл хөвгүүдийн, костюм, хослол, хүрэм г.м.-нийлэг мяндсан	10%
22	6103.49	Эрэгтэйчүүдийн, эсхүл хөвгүүдийн костюм, хослол, хүрэм г.м.-бусад нэхмэлийн материалан	10%
23	6105.10	Эрэгтэйчүүдийн, эсхүл хөвгүүдийн сүлжмэл, цамц.-хөвөн даавуун	10%
24	6105.20	Эрэгтэйчүүдийн, эсхүл хөвгүүдийн сүлжмэл, цамц.-нийлэг мяндсан	10%
25	6105.90	Эрэгтэйчүүдийн, эсхүл хөвгүүдийн сүлжмэл цамц.-бусад нэхмэлийн материалан	10%
26	6106.10	Эмэгтэйчүүдийн, эсхүл охидын сүлжмэл кофт, цамц, блузк.-хөвөн	10%
27	6106.20	Эмэгтэйчүүдийн, эсхүл охидын сүлжмэл кофт, цамц, блузк.-нийлмэл мяндсан	10%
28	6106.90	Эмэгтэйчүүдийн, эсхүл охидын сүлжмэл кофт, цамц, блузк.-бусад нэхмэлийн материалан	10%
29	6107.11	Эрэгтэйчүүдийн, эсхүл хөвгүүдийн сүлжмэл дотуур өмд-хөвөн	10%
30	6107.21	Унтлагын цамц, унтлагын өмд цамцны хослол-хөвөн	10%
31	6107.22	Унтлагын цамц, унтлагын өмд цамцны хослол-химийн мяндсан	10%
32	6107.29	Унтлагын цамц, унтлагын өмд цамцны хослол -нэхмэлийн бусад материалан	10%
33	6108.31	Унтлагын цамц, унтлагын өмд цамцны хослол-хөвөн	10%
34	6108.32	Унтлагын цамц, унтлагын өмд цамцны хослол-химийн мяндсан	10%
35	6108.39	Унтлагын хувцас, унтлагын өмд цамцны хослол - нэхмэлийн бусад материалан	10%
36	6109.10	Сүлжмэл футболка, майк болон бусад дотуур цамц-хөвөн	10%
37	6110.20	Сүлжмэл цамц, пуловер, кардиган г.м. - хөвөн	10%
38	6110.30	Сүлжмэл цамц, пуловер, кардиган, г.м. - химийн мяндсан	10%

39	6110.90	Сүлжмэл цамц зэрэг-бусад нэхмэлийн материалан	10%
40	6113.00	Сүлжмэл материалаар хийсэн хувцас.	10%
41	6114.20	Бусад сүлжмэл материалаар хийсэн хувцас	10%
42	6203.32	Пиджак, хүрэм-хөвөн	10%
43	6203.33	Пиджак, хүрэм-химийн нийлэг	10%
44	6203.39	Пиджак, хүрэм- бусад нэхмэлийн материалан	10%
45	6203.42	Эрэгтэйчүүдийн, эсхүл хөвгүүдийн урт өмд, энгэрэвчтэй болон мөрөвчтэй комбинзон, хагас урт өмд, богино өмд-хөвөн	10%
46	6203.43	Эрэгтэйчүүдийн эсхүл хөвгүүдийн урт өмд, энгэрэвчтэй болон мөрөвчтэй комбинзон, хагас урт өмд, богино өмд-химийн нийлэг материалан, сүлжмэл бус	10%
47	6203.49	Эрэгтэйчүүдийн эсхүл хөвгүүдийн урт өмд, энгэрэвчтэй болон мөрөвчтэй комбинзон, хагас урт өмд, богино өмд-нэхмэлийн бусад материалан, сүлжмэл бус	10%
48	6204.32	Пиджак, хүрэм- хөвөн	10%
49	6204.33	Пиджак, хүрэм- химийн нийлэг	10%
50	6204.39	Пиджак, хүрэм- бусад сүлжмэл материалан	10%
51	6204.62	Эмэгтэйчүүд, охидын өмд, энгэрэвчтэй болон мөрөвчтэй комбинзон, хагас урт өмд, богино өмд- хөвөн	10%
52	6204.63	эмэгтэйчүүд, охидын өмд, энгэрэвчтэй болон мөрөвчтэй комбинзон, хагас урт өмд, богино өмд- химийн нийлэг материалан, сүлжмэл бус	10%
53	6205.20	Эрэгтэйчүүдийн, эсхүл хөвгүүдийн цамц-хөвөн	10%
54	6205.30	Эрэгтэйчүүдийн, эсхүл хөвгүүдийн оёмол цамц-химийн нийлэг	10%
55	6205.90.90	Эрэгтэйчүүдийн, эсхүл хөвгүүдийн оёмол цамц-бусад сүлжмэл материалан	10%
56	6206.30	Эмэгтэйчүүдийн, эсхүл охидын блузк, цамц, кофт- хөвөн	10%
57	6206.90	Эмэгтэйчүүдийн эсхүл охидын блузк, цамц, кофт- бусад сүлжмэл материалан	10%
58	6210.10	Нэвчүүлсэн, бүрсэн, хучсан буюу үелүүлсэн, эсхүл ийм боловсруулалт хийгээгүй эсгий, эсхүл нэхээсгүй материалан хувцас –хөвөн	10%
59	6210.20	Амьтны нарийн үсэн материалан бусад хувцас, сүлжмэл бус	10%
60	6210.40	Эрэгтэйчүүд, хөвгүүдийн бусад хувцас	10%
61	6210.50	Эмэгтэйчүүд, охидын бусад хөвөн хувцас	10%
62	6302.10	Орны сүлжмэл даавуун хэрэглэл, сүлжмэл	16%
63	6302.21	Ор, ширээ,, ариун цэврийн болон гал тогооны сүлжмэл даавуун хэрэглэл-хөвөн	16%
64	6302.22	Химийн нийлэг мяндсан	16%
65	6302.29	Бусад сүлжмэл материалаар хийсэн	16%
66	6302.31	Бусад орны цагаан хэрэглэл-хөвөн	16%
67	6302.32	Бусад орны цагаан хэрэглэл-химийн нийлэг мяндсан	16%



68	6909.90	Лаборатори, химийн үйлдвэрлэл, техникийн бусад зориулалттай керамик сав суулга; ХАА-н зориулалттай тэвш, ган, торх болон бусад сав; барааг савлах, зөөвөрлөхөд ашигладаг керамик сав суулга болон эдгээртэй төстэй зүйлс-бусад	10%
69	8215.20	Сонгож авсан эдлэлийн бусад иж бүрдэл	50%
70	8215.91	Гал зуух, хоолны хэрэгсэл-үнэт металлаар бүрсэн	50%
71	8215.99	Халбага, сэрээ, хоолны халбага, шүүрэн шанага, тортны хусуур, загасны хутга-бусад	50%
72	8414.51	Ширээ, шал, хана, цонх, тааз, эсхүл дээвэрт байрлуулах зориулалттай, цахилгаан хөдөлгүүрт салхилуур	33.5%
73	8506.90	Хуурай элементийн зай	10%
74	8507.90	Аккумуляторын эд анги	10%
75	8546.20	Керамик материалаар хийсэн цахилгаан тусгаарлагч	25%

Хавсралт II

**АЗИ, НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ
ХЭЛЭЛЦЭЭРИЙН ГАРАЛ ҮҮСЛИЙН ДҮРЭМ**

Энэхүү хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасны дагуу Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн хөнгөлөлтөд хамрагдах нөхцөл хангасан барааны гарал үүслийг тодорхойлоход дараах дүрмийг баримтална:

1 дүгээр дүрэм. Гарал үүсэлтэй бараа

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд хөнгөлөлттэй худалдаанд хамаарах Оролцогч нэг улсын нутаг дэвсгэрээс Оролцогч нөгөө улсын нутаг дэвсгэр рүү импортлохдоо 5 дугаар дүрмийн дагуу шууд ачуулсан бараа нь дор дурдсан аль нэг нөхцөлийн дагуу гарал үүслийн шалгуурыг хангавал хөнгөлөлтөд хамрагдах эрхтэй:

- (a) 2 дугаар дүрэмд заасны дагуу экспортлогч улсад бүрэн үйлдвэрлэгдсэн, эсхүл боловсруулагдсан бүтээгдэхүүн; эсхүл
- (b) бүтээгдэхүүн нь экспортлогч улсад бүрэн үйлдвэрлэгдээгүй, эсхүл боловсруулагдаагүй боловч 3 ба 4 дүгээр дүрмийн нөхцөлийг хангасан.

2 дугаар дүрэм. Бүрэн үйлдвэрлэгдсэн, эсхүл боловсруулагдсан

1 дүгээр дүрмийн (a) хэсгийн хүрээнд дараахыг экспортлогч улсад бүрэн боловсруулсан, эсхүл үйлдвэрлэсэнд тооцно:

- (a) газрын хэвлий, ус, далайн гүнээс олборлосон түүхий эд, эрдсийн бүтээгдэхүүн;¹
- (b) тухайн улсын нутаг дэвсгэрээс хураасан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн;²
- (c) тухайн улсын нутаг дэвсгэрт төрсөн, бойжсон амьтан;
- (d) дээрх (c) хэсэгт заасан амьтны гаралтай бүтээгдэхүүн;
- (e) тухайн улсын нутаг дэвсгэрт хийсэн агнуур, загасчлалын гаралтай бүтээгдэхүүн;
- (f) өөрийн хөлөг онгоцоор хийсэн далайн загас агнуур болон бусад далайн гаралтай бүтээгдэхүүн;^{3/4}
- (g) зөвхөн дээрх (f) хэсэгт заасан бүтээгдэхүүнийг ашиглан боловсруулах онгоцон^{4/5} дээр боловсруулсан болон/эсхүл үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн;
- (h) анхны зориулалтаараа ашиглах боломжгүй болсон хэрэглэсэн эд зүйлээс гаргаж авсан сэлбэг, түүхий эд;
- (i) тухайн улсын нутаг дэвсгэрээс цуглуулсан анхны зориулалтынх нь дагуу ашиглах, засварлах, сэргээх боломжгүй болсон зөвхөн хаях, эсхүл түүхий эд, сэлбэгийн зорилгоор ашиглах боломжтой хэрэглэсэн эд зүйлс;
- (j) тухайн улсын нутаг дэвсгэрт явуулсан үйлдвэрлэлийн явцад бий болсон хаягдал;
- (k) зөвхөн (a) болон (j) хэсэгт заасан бүтээгдэхүүнээр тухайн улсад хийсэн бараа бүтээгдэхүүн.



3 дугаар дүрэм. Бүрэн үйлдвэрлэгдээгүй, эсхүл боловсруулагдаагүй

- (a) 1 дүгээр дүрмийн (b) хэсгийн хүрээнд Оролцогч бус улсын гарал үүсэлтэй, эсхүл гарал үүсэл нь тодорхойгүй түүхий эд, сэлбэг, бүтээгдэхүүний нийт үнэ үйлдвэрлэсэн болон боловсруулсан бүтээгдэхүүний f.o.b үнийн 55 хувиас хэтрээгүй бөгөөд үйлдвэрлэлийн сүүлийн үйл явц экспортлогч Оролцогч улсын нутаг дэвсгэрт хийгдсэн бол тухайн боловсруулсан бүтээгдэхүүн 3 дугаар дүрмийн (c), (d) болон (e) хэсгийн заалтын дагуу хөнгөлөлтөд хамрагдах эрхтэй.
- (b) Салбар хоорондын хэлэлцээр⁶
- (c) Гарал үүсэлгүй материалын орц болон 3 дугаар дүрмийн (a) хэсэгт заасан гарал үүслийн төлөвийг хүлээн зөвшөөрөх шаардлагыг тодорхойлохдоо дараах томъёог ашиглана.

$$\frac{\text{Импортолсон гарал үүсэлгүй материал, сэлбэг, бүтээгдэхүүний өртөг} + \text{Гарал үүсэл нь тодорхойгүй сэлбэг, бүтээгдэхүүний өртөг}}{\text{f.o.b. үнэ}} * 100 \leq 55\%$$

(d) Гарал үүсэлгүй материал, сэлбэг, бүтээгдэхүүний өртөг нь:

- i) Материал, сэлбэг, бүтээгдэхүүнийг импортлох үеийн c.i.f. үнийг нотлох боломжтой бол энэ үнэ; эсхүл
 - ii) Боловсруулалт хийгддэг Оролцогч улсын нутаг дэвсгэр дээрх гарал үүсэл нь тодорхойгүй материал, сэлбэг, бүтээгдэхүүнд төлсөн анхны баталгаажсан үнэ.
- (e) 1 дүгээр дүрмийн (b) хэсэг дэх шаардлагыг хангасан эсэхээс үл хамааран дараах боловсруулалт, үйл ажиллагааг гарал үүслийн төлөв олгоход хангалттай биш гэж үзнэ. Үүнд:
- i) Бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн явцад сайн чанарыг хадгалахын тулд хийгдэж буй үйл ажиллагаа (агааржуулалт, тархаах, хатаах, хөргөх, давс, хүхэрийн исэл болон бусад усан уусмалд байлгах, гэмтэлтэй хэсгийг арилгах, бусад ижил төстэй үйл ажиллагаа);
 - ii) Тоос арилгах, шигших, эсхүл хяналт шалгалт хийх, ангилах, ялгах, ижилсүүлэх (багцлах), угаах, будах, хэрчих зэрэг энгийн үйл ажиллагаа;
 - iii) Баглаа боодлыг өөрчлөх, ачааг задлах болон цуглуулах;
 - iv) Зүсэх, хэрчих, дахин баглах, шил, дашмаг, уут, хайрцганд савлах, карт, эсхүл самбар дээр тохируулах гэх мэт;
 - v) Барааны тэмдэг, шошго болон бусад ижил төрлийн онцгой тэмдэглэгээг бүтээгдэхүүн болон түүний баглаа боодол дээр хийх;
 - vi) Энгийн холих үйлдэл;
 - vii) Нэг бүрэн бүтээгдэхүүн бий болгох зорилгоор бүтээгдэхүүний эд ангийг угсрах энгийн үйлдэл;
 - viii) Мал, амьтан нядлах;
 - ix) Хальслах, үртсээс салгах, тарианы хог цэвэрлэх, яснаас салгах;
 - x) Дээр дурдсан үйлдлийн хоёр болон түүнээс дээш үйлдлийн хослол.

4 дүгээр дүрэм. Нийлмэл гарал үүслийн дүрэм

1 дүгээр дүрэмд заасан гарал үүслийн шаардлагыг хангасан, Оролцогч өөр нэг улсын хөнгөлөлтийн нөхцөлийг хангасан эцсийн бүтээгдэхүүний орц болгож Оролцогч улсын ашигласан бүтээгдэхүүнийг Оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарал үүсэл бүхий агууламжийн нийлбэр⁹ нь f.o.b үнийн 60 хувиас бага биш бол эцсийн боловсруулалт хийсэн Оролцогч улсын гарал үүсэлтэйд тооцно.⁷

5 дугаар дүрэм. Барааг шууд ачих

Дараах тохиолдолд экспортлогч Оролцогч улсаас импортлогч Оролцогч улс руу барааг шууд ачуулсанд тооцно. Үүнд:

- (a) Хэрэв бүтээгдэхүүн нь аль нэг Оролцогч бус улсын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөөгүй бол;
- (b) Бүтээгдэхүүний тээвэрлэлт нь хоёр болон түүнээс дээш Оролцогч бус завсрын улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөхдөө дамжуулан тээвэрлэлт, түр хадгалалт хийсэн эсэхээс үл хамааран дараах нөхцөлийг хангасан бол:
 - i) газарзүйн, эсхүл зөвхөн тээвэрлэлтийн нөхцөлтэй холбогдох шалтгаанаар дамжин өнгөрөх шаардлагатай нь тогтоогдсон;
 - ii) тухайн бүтээгдэхүүн нь дамжин өнгөрсөн улсад худалдаа, эсхүл хэрэглээнд ороогүй;¹⁰
 - iii) ачих, буулгах, хадгалалтын горимыг хангах үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа хийгдээгүй.

6 дугаар дүрэм. Савлагааны горим

Бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлохдоо бүтээгдэхүүний савлагааг тухайн бүтээгдэхүүнтэй нэг хэсэг гэж үзнэ. Гэхдээ үндэсний хууль тогтоомжид заасны дагуу баглаа боодлыг салангид авч үзэж болно.

7 дугаар дүрэм. Гарал үүслийн гэрчилгээ

Хөнгөлөлтөд хамрагдах бараа нь экспортлогч Оролцогч улсын Засгийн газраас томилсон эрх бүхий байгууллагаас олгосон Гарал үүслийн гэрчилгээтэй байх бөгөөд хавсралтад заасан Гарал үүслийн гэрчилгээний загвар болон түүнийг бөглөх зааврын дагуу Оролцогч бусад улсуудад мэдэгдэнэ.

8 дугаар дүрэм. Хориглох зүйл ба хамтын ажиллагаа

(a) Аливаа Оролцогч улс нь эдийн засаг, худалдааны харилцаагүй улсаас гарал үүсэл бүхий аливаа орц агуулагдсан бүтээгдэхүүний импортыг хориглож болно.

(b) Оролцогч улсууд нь Гарал үүслийн гэрчилгээнд орцын гарал үүслийг тодорхой тусгах зорилгоор хамтран ажиллахад хүч чармайлт гаргана.

9 дүгээр дүрэм. Хянан үзэх

Энэхүү дүрмийг Оролцогч улсуудын гуравны нэг нь хүсэлт гаргаснаар шаардлагатай тохиолдолд хянан үзэж болох бөгөөд тохиролцсоны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулахад нээлттэй байж болно.

10 дугаар дүрэм. Тусгай шалгуурын хувь хэмжээ

Буурай хөгжилтэй улсын гарал үүсэлтэй бүтээгдэхүүний хувьд 3 ба 4 дүгээр дүрэмд заасан хувь хэмжээн дээр нэмэлт 10 хувийг олгож болно. Гэхдээ 3 дугаар дүрмийн хувь хэмжээ 65-аас ихгүй, 4 дүгээр дүрмийн хувь хэмжээ 50-иас багагүй байна.

Зүүлт тайлбар

1. Эрдэс түлш, тосолгооны материал болон холбогдох материал мөн ашигт малтмал, эсхүл металлын хүдэр зэрэг багтана.
2. Ойн аж ахуйн бүтээгдэхүүн хамаарна.



3. “Хөлөг онгоц” гэдэг нь Оролцогч улсын иргэн буюу иргэд, эсхүл Засгийн газар, эсхүл тухайн Оролцогч улсад зохих ёсоор бүртгэгдсэн бөгөөд хөрөнгийнх нь 60-аас доошгүй хувийг тухайн Оролцогч улсын иргэн буюу иргэд, эсхүл/болон Засгийн газар нь эзэмшдэг, эсхүл 75 хувийг нь Оролцогч улсуудын иргэд буюу/болон Засгийн газар эзэмшдэг түншлэл, корпораци буюу холбооноос үйл ажиллагааг нь явуулдаг арилжааны загас агнуурын хөлөг онгоцыг хэлнэ. Гэхдээ хөлөг онгоц хөлслөх/түрээслэх, болон/эсхүл Оролцогч улсууд хооронд агнасан загасаа хуваалцах асуудлыг зохицуулсан хоёр талын гэрээнд заасан арилжааны загас агнуурын үйл ажиллагаанд оролцсон хөлөг онгоцноос авсан бүтээгдэхүүн мөн давуу хөнгөлөлт авах эрхтэй байна.
4. Засгийн газрын агентлаг үйл ажиллагааг нь эрхэлдэг хөлөг онгоц, эсхүл боловсруулах онгоцонд Оролцогч улсын далбааг мандуулах шаардлага тавигдахгүй.
5. Энэхүү хэлэлцээрийн зорилгоор “Боловсруулах онгоц” гэдэг нь зөвхөн дээрх (f) хэсэгт заасан бүтээгдэхүүнийг ашиглан хөлөг онгоцны тавцан дээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хийх зориулалт бүхий хөлөг онгоцыг хэлнэ.
6. Хавсралт II.A-д заасны дагуу.
7. Дээрх 4 дүгээр дүрэмд заасан “Хэсэгчилсэн” нийлмэл гэдэг нь аль нэг Оролцогч улсын нутаг дэвсгэрээс гаралтай бүтээгдэхүүнийг 3 дугаар дүрмийн (e) хэсэгт заасны дагуу өөр нэг Оролцогч улсын нутаг дэвсгэрт хөнгөлөлттэй нөхцөлд хамрагдах боломж бүхий эцсийн бүтээгдэхүүний орц болгон ашигласан тохиолдолд харгалзан үзэхийг хэлнэ.
8. Оролцогч улсуудын баталсан Оролцогч улсууд нийтээр ашиглах стандарт Гарал үүслийн гэрчилгээг хавсаргав.
9. 4 дүгээр дүрэмд заасан “нийлмэл агууламж”-ийг орц болгон ашигласан гарал үүсэл бүхий материалын үнэ (ГҮМҮ1) болон эцсийн бүтээгдэхүүнийг боловсруулсан Оролцогч улсаас нэмсэн гарал үүсэл бүхий материалын үнийн (ГҮМҮ2) дүнгийн нийлбэрээр тооцож бодно. ГҮМҮ1 гэж өмнөх Оролцогч улсын нутаг дэвсгэрээс гаралтай бүтээгдэхүүний үнийг хэлэх бөгөөд уг үнийг Гаалийн үнэлгээний хэлэлцээрийн 1-8 дугаар зүйл, 15 дугаар зүйл болон холбогдох тайлбарын дагуу тодорхойлсон гаалийн үнэд үндэслэн тооцоолно. ГҮМҮ2 гэж эцсийн бүтээгдэхүүнийг боловсруулсан Оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарал үүсэл бүхий материалын үнэ болон шууд хөдөлмөрийн хөлс, шууд нэмэлт зардал, тээврийн зардал болон эцсийн бүтээгдэхүүний ашиг зэрэг тухайн Оролцогч улсад эцсийн бүтээгдэхүүнийг боловсруулахад ашигласан орцын үнийг хэлнэ. Дээрх тайлбарын дагуу ГҮМҮ1 болон ГҮМҮ2 –ийн нийлбэр f.o.b үнийн 60 хувиас багагүй бол тухайн бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүнийг боловсруулсан Оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй гэж үзнэ.
10. 5(b)(ii) дахь дүрэмд “тухайн бүтээгдэхүүн нь дамжин өнгөрсөн улсад худалдаа, эсхүл хэрэглээнд ороогүй” гэснийг Оролцогч бус дундын улсын гаалийн байгууллагын хяналтад байгаа боловч импортын хяналт, шалгалт хийлгээгүй бүтээгдэхүүнийг экспортлогч Оролцогч улсаас импортлогч Оролцогч улс руу шууд ачуулсан гэж тайлбарлана. “Худалдаанд, эсхүл хэрэглээнд орсон бүтээгдэхүүн” гэх нэр томъёог тухайн бүтээгдэхүүний импортын мэдэгдлийг хүлээн авсан бөгөөд хэрэглэх, эсхүл өөр гэрээний дагуу экспортлох зорилгоор гаалийн хяналтын бүсээс дундын улсын дотоодын зах зээл рүү гаргасан бүтээгдэхүүн гэж ойлгоно. Иймээс гаалийн байгууллагын хяналт дор гаалийн хяналтын бүсэд түр хадгалагдаж байгаа бөгөөд 5(b)(iii) дахь дүрэмд тодорхойлсноос өөр үйл ажиллагаа хийгдээгүй бол уг бүтээгдэхүүнийг худалдаанд, эсхүл хэрэглээнд ороогүй гэж ойлгоно.

ГАРАЛ ҮҮСЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр
(Нэгтгэсэн мэдэгдэл болон гэрчилгээ)

1. Бараа, бүтээгдэхүүнийг ачуулсан улс: (Экспортлогчийн албаны нэр, хаяг, улсын нэр)		Баталгаажуулалтын дугаар:олгов. (улсын нэр)			
2. Хүлээн авагч улс: (Ачуулсан хүний нэр, хаяг, улсын нэр)		3. Албан хэрэгцээнд:			
4. Тээвэрлэлтийн хэлбэр, маршрут:					
5. Барааны Тарифын код:	6. Сав, баглаа боодлын марк, дугаар:	7. Сав, баглаа боодлын төрөл, дугаар, бүтээгдэхүүний тодорхойлолт:	8. Гарал үүслийн шалгуур: (хуудасны ар талын тэмдэглэлийг харна уу)	9. Нийт жин, эсхүл бусад хэмжээ:	10. Нэхэмжлэл-ийн дугаар, огноо:
11. Экспортлогчийн мэдэгдэл: Бүх бараа бүтээгдэхүүн-д үйлдвэрлэгдсэн бөгөөд (улсын нэр) Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн тухайн бараанд зориулсан гарал үүслийн шалгуурыг хангаж-д экспортолсон бөгөөд дээр (импортлогч улс) дурдсан мэдээлэл үнэн зөв болохыг дор гарын үсэг зурсан этгээд ийнхүү нотолж байна. Газар, огноо, баталгаат гарын үсэг			12. <u>Гэрчилгээ</u> Экспортлогчийн мэдэгдэл үнэн зөв болохыг шалгалтаар баталгаажуулав. Газар, огноо, баталгаажуулагчийн гарын үсэг болон тэмдэг		

Гарал үүслийн гэрчилгээ бөглөх тайлбар

I. Ерөнхий нөхцөл

Хөнгөлөлтөд хамрагдахын тулд бүтээгдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

а) Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн хүлээн авагч улсын хөнгөлөлтийн жагсаалтын хөнгөлөлт эдлэх бүтээгдэхүүний тодорхойлолтод нийцсэн байх;

б) Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн гарал үүслийн дүрмийг хангасан. Ачаан дахь бараа тус бүр нь дүрмийг хангасан байх; бөгөөд

в) Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн гарал үүслийн дүрмийн бараа ачуулах тусгай журмыг хангасан байх. Ерөнхийдөө 5 дугаар дүрэмд зааснаар экспортлогч улсаас импортлогч улс руу шууд ачуулсан байх.



II. Хүснэгтэд оруулах мэдээлэл

1 дүгээр нүд. Бараа, бүтээгдэхүүн хаанаас ачигдсан

Экспортлогчийн нэр, хаяг, улсын нэрийг бичнэ. Экспортлогчийн нэр нь нэхэмжлэл дээрх экспортлогчтой ижил байна.

2 дугаар нүд. Хүлээн авагч улс

Импортлогчийн нэр, хаяг, улсын нэрийг бичнэ. Импортлогчийн нэр нэхэмжлэл дээрх импортлогчтой ижил байна. Гуравдагч талын худалдааны хувьд «захиалгад» гэсэн үг бичиж болно.

3 дугаар нүд. Албан хэрэгцээнд

Баталгаажуулах эрх бүхий этгээдийн хэрэглээнд үлдээнэ.

4 дүгээр нүд. Тээвэрлэлтийн хэлбэр, маршрут

Экспортолж буй барааны тээвэрлэлтийн хэлбэр, маршрутыг нарийвчлан заана. Хэрвээ аккредитивийн нөхцөл зэргийн дагуу ийнхүү нарийвчлах шаардлагагүй бол зөвхөн «агаараар», «далайгаар» гэж бичнэ. Хэрэв тухайн бараа гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа бол дараах байдлаар тодорхойлж болно:

Тухайлбал: “агаараар”
“Лаосаас Бангкокоор дамжин Энэтхэг хүртэл”

5 дугаар нүд. Барааны тарифын код

Бараа тус бүрийн Уялдуулсан Системийн 4 оронтой кодыг бичнэ.

6 дугаар нүд. Сав, баглаа боодлын марк, дугаар

Гэрчилгээний дагуу сав, баглаа боодлын марк, дугаарыг бичнэ. Уг мэдээлэл нь сав, баглаа боодол дээрх марк, дугаартай ижил байна.

7 дугаар нүд. Сав баглаа боодлын төрөл, дугаар, бүтээгдэхүүний тодорхойлолт

Экспортолсон барааны тодорхойлолтыг ойлгомжтой бичнэ. Энэ нь нэхэмжлэл дээрх тодорхойлолттой ижил байна. Үнэн зөв тодорхойлолт нь хүлээн авагч улсын Гаалийн байгууллага барааг шуурхай нэвтрүүлэхэд тустай.

8 дугаар нүд. Гарал үүслийн шалгуур

Хөнгөлөлт эдлэх бүтээгдэхүүн нь Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн Гарал үүслийн дүрмийн 2 дугаар дүрэмд зааснаар экспортлогч Оролцогч улсад бүрэн үйлдвэрлэгдсэн, эсхүл боловсруулагдсан, эсхүл экспортлогч Оролцогч улсад бүрэн үйлдвэрлэгдээгүй, боловсруулагдаагүй бол 3 ба 4 дүгээр дүрмийн шалгуурыг хангасан байна.

а) Бүрэн үйлдвэрлэгдсэн, эсхүл боловсруулагдсан бүтээгдэхүүн: “А” үсгийг 8 дугаар нүдэнд оруулна.

б) Бүрэн үйлдвэрлэгдээгүй, эсхүл боловсруулагдаагүй бүтээгдэхүүн: 8 дугаар нүдэнд оруулах мэдээллийг дараах байдлаар бөглөнө:

1. 3 дугаар дүрмийн гарал үүслийн шалгуурыг хангаж байгаа бүтээгдэхүүн бол 8 дугаар нүдэнд “В” үсэг оруулна. “В” үсгийн дараа Оролцогч бус улсаас гарал үүсэлтэй түүхий эд, сэлбэг, бүтээгдэхүүний нийт үнэ, эсхүл гарал үүсэл нь

тодорхойгүй бүтээгдэхүүн бол бүтээгдэхүүний f.o.b үнийн дүнг хувиар бичнэ (Жишээлбэл: “B” 50 хувь);

2. 4 дүгээр дүрмийн гарал үүслийн шалгуурыг хангаж байгаа бүтээгдэхүүн бол 8 дугаар нүдэнд “C” үсэг оруулна. “C” үсгийн дараа экспортлогч Оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй агууламжийн нийлбэрийг f.o.b үнийн дүнгийн хувиар бичнэ. (Жишээлбэл: “C” 60 хувь)
3. 10 дугаар дүрмийн гарал үүслийн тусгай шалгуурыг хангаж байгаа бүтээгдэхүүн бол 8 дугаар нүдэнд “D” үсэг оруулна.
4. 3 дугаар дүрмийн (b) хэсэгт заасан гарал үүслийн шалгуурыг хангаж байгаа бүтээгдэхүүн бол 8 дугаар нүдэнд “E” үсэг оруулна. “E” үсгийн дараа Гарал үүслийн дүрмийн шалгуурыг бичнэ (Жишээлбэл: “E” СТН).

9 дүгээр нүд. Нийт жин, эсхүл бусад хэмжээ

Гэрчилгээнд дурдсан бүтээгдэхүүний нийт жин, эсхүл бусад хэмжээ (ширхэг, кг гэх мэт)-г бичнэ.

10 дугаар нүд. Нэхэмжлэлийн дугаар, огноо

Тухайн нэхэмжлэлийн дугаар, огноог тодорхой бичнэ. Мэдүүлэгт хавсаргасан нэхэмжлэлийн огноо нь гэрчилгээн дэх баталгаажуулсан огнооноос хойш байж болохгүй.

11 дүгээр нүд. Экспортлогчийн мэдэгдэл

“Экспортлогч” гэж илгээгчийг хэлэх бөгөөд энэ нь үйлдвэрлэгч, эсхүл худалдаа эрхлэгчийн аль нэг нь байж болно. Үйлдвэрлэгч улсын нэр, импортлогч улсын нэр, мэдэгдэл хийсэн газар, огноог бичнэ. Энэ нүдэнд компанийн эрх бүхий этгээд гарын үсэг зурна.

12 дугаар нүд. Гэрчилгээ

Гэрчилгээ олгох эрх бүхий байгууллага энэхүү хүснэгтийг баталгаажуулна.

АНДХХ-ийн Хавсралт II.A

АНДХХ-ИЙН САЛБАРЫН ГАРАЛ ҮҮСЛИЙН ДҮРЭМ

Тэмдэглэл:

1. Гарал үүслийн 3 дугаар дүрмийн 3(b) хэсгийн дагуу (АНДХХ-ийн Хавсралт II) 3 дугаар баганад тодорхойлсон шалгуур нь доорх жагсаалтад тусгасан бараанд үйлчилнэ.
2. 3 дугаар багана болон 3 дугаар дүрмийн 3 (a) хэсэгт заасан гарал үүслийн шалгуурыг тодорхой нэр төрлийн бараанд тус тус дараалан хэрэглэнэ. Тухайн бараа 3 дугаар баганад заасан шалгуурыг хангаагүй бол 3 дугаар дүрмийн 3 (a) хэсэг үйлчилнэ.
3. Тарифын зүйл, мөрийн өөрчлөлт (ТЗМӨ) гэснийг тухайн гарал үүсэлгүй материалын Барааг тодорхойлох, кодлох, уялдуулсан систем дэх тарифын ангилал нэг мөрнөөс нөгөө мөрөнд шилжин өөрчлөгдсөн гэж ойлгоно.
4. Үйлдвэрлэлийн эцсийн шат экспорт хийж буй Оролцогч улсын нутаг дэвсгэрт хийгдэнэ.



Уялдуулсан системийн зүйл, мөр	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн шалгуур
2201	Ундаа, спирт болон цуу	ТЗМӨ
2707, 2708, 2709, 2710, 2711, 2712, 2713, 2714, 2715	Эрдэст түлш	ТЗМӨ
2901, 2902, 2903, 2904, 2905, 2906, 2907, 2908, 2909, 2910, 2911, 2912, 2913, 2914, 2915, 2931, 2932, 2933, 2934, 2935, 2936, 2937, 2938, 2939, 2940, 2941, 2942	Органик химийн бодис	ТЗМӨ
3817	Холимог алкилбензин	ТЗМӨ
3901, 3902, 3903, 3904, 3905, 3906	Пластик болон пластикаар хийсэн зүйлс	ТЗМӨ
3916, 3917, 3918, 3919, 3920, 3921, 3922, 3923, 3924, 3925, 3926		ТЗМӨ
4002	Нийлэг хаймар	4001-ээс бусад нь ТЗМӨ
6401, 6402, 6403, 6404, 6405, 6406	Гутал, түрий болон ижил төстэй зүйлс, тэдгээрийн эд анги	ТЗМӨ
6801, 6802, 6803	Чулуу, гипс, цемент, асбест, гялтгануур, эсхүл ижил материалаар хийсэн зүйл	ТЗМӨ
7201, 7202, 7203, 7204, 7205, 7206, 7218, 7224	Төмөр, ган	ТЗМӨ
7307, 7308, 7309, 7310, 7311, 7312, 7313, 7314, 7315, 7316, 7317, 7318, 7319, 7320, 7321, 7322, 7323, 7324, 7325, 7326	Төмрөөр болон гангаар хийсэн зүйл	ТЗМӨ
7401, 7402, 7403, 7404, 7405, 7406, 7407, 7408, 7409, 7410, 7411, 7412, 7413, 7414, 7415, 7416, 7417, 7418, 7419	Зэс болон зэсээр хийсэн зүйл	ТЗМӨ
7501, 7502, 7503, 7504, 7505, 7506, 7507, 7508	Никел болон никелээр хийсэн зүйл	ТЗМӨ
7601, 7602, 7603, 7604, 7605, 7606, 7607, 7608, 7609, 7610, 7611, 7612, 7613, 7614, 7615, 7616	Хөнгөн цагаан болон хөнгөн цагаанаар хийсэн зүйл	ТЗМӨ
7801, 7802, 7803, 7804, 7805, 7806	Хар тугалга болон хар тугалгаар хийсэн зүйл	ТЗМӨ
7901, 7902, 7903, 7904, 7905, 7906, 7907	Цайр болон цайраар хийсэн зүйл	ТЗМӨ
8001, 8002, 8003, 8004, 8005, 8006, 8007	Цагаан тугалга болон цагаан тугалгаар хийсэн зүйл	ТЗМӨ

2. АЗИ, НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ОРОЛЦОГЧ УЛСАД ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ ТУХАЙ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

(цаашид "энэхүү хэлэлцээр" гэх)

Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс болон Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улсын Засгийн газар, Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (АНДХХ)-ийн оролцогч улсууд (цаашид "Оролцогч улс" гэх);

АНДХХ-ийн хүрээнд хамтын зүтгэлээр худалдаа, хөрөнгө оруулалтын урсгалыг идэвхжүүлэх, худалдааг чөлөөлөх замаар Оролцогч бүх улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийг тогтворжуулахын чухлыг **НОТОЛЖ**;

Оролцогч улсын худалдааг хөнгөвчлөх асуудлаарх болон Дэлхийн худалдааны байгууллагын Дохагийн хөгжлийн хөтөлбөрийн худалдааг хөнгөвчлөх яриа хэлэлцээний хүрээнд хамтран ажиллах шаардлага нэмэгдэж буйг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ**;

Киотогийн конвенцын шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэхийн чухлыг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ**;

Оролцогч улсууд худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ зэрэг худалдааг чөлөөлөхөд дөхөм болох хилийн болон хилийн бус арга хэмжээтэй холбоотой хамтын ажиллагааны бусад салбарыг эрэлхийлнэ гэж заасан АНДХХ-ийн 11 дүгээр зүйлийг **САНАЖ**;

АНДХХ-ийн 12 дугаар зүйлийн (с), (ф), (f) хэсэгт заасан худалдааг хөнгөвчлөхтэй холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлэх, хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх шаардлагатайг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ**;

Энэтхэг Улсын Гао хотноо 2007 оны 10 дугаар сарын 26-ны өдөр болсон Сайд нарын зөвлөлийн хоёр дахь удаагийн чуулга уулзалтын үеэр баталсан АНДХХ-ийн сайд нарын тунхаглалаар яриа хэлэлцээг тарифын бус арга хэмжээ, худалдааг хөнгөвчлөх, үйлчилгээ болон хөрөнгө оруулалт зэрэг салбараар өргөжүүлэх аргачлалыг даруй батлах чиглэлийг Байнгын хороонд өгснийг **САНАЖ**;

Худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ авах замаар Оролцогч улсын худалдааны өрсөлдөх чадвар, ур ашгийг тогтворжуулан, ахиулахыг **ЭРМЭЛЗЭН**;

Оролцогч улсын хөгжлийн түвшин харилцан адилгүй байгааг **АНХААРЧ**;

Оролцогч улс хооронд худалдааг хөнгөвчлөх хамтын ажиллагааг гунзгийрүүлэн өргөжүүлэх ерөнхий бүтцийг боловсруулах, энэ чиглэлээр цаашид хийх үйл ажиллагааг төлөвлөхийг **ЭРМЭЛЗЭН**;

Оролцогч улсууд худалдааг чөлөөлөхөд дөхөм болох хилийн болон хилийн бус арга хэмжээтэй холбоотой хамтын ажиллагааны бусад салбарыг эрэлхийлнэ гэж заасан АНДХХ-ийн 11 дүгээр зүйл, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай АНДХХ-ийн 26 дугаар зүйлийг тус тус **ҮНДЭСЛЭН**;

Дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Хамрах хүрээ

Энэхүү хэлэлцээр нь Оролцогч бүх улс болон Оролцогч улс хооронд дотоодын хууль тогтоомж, захиргааны шийдвэрийн дагуу худалдсан бүх бараанд үйлчилнэ.



2 дугаар зүйл

Зорилго

Энэхүү хэлэлцээрийн зорилго нь худалдааны дүрэм, журам болон дадлыг уялдуулж, хялбаршуулах замаар хил дамнасан барааны худалдаатай холбоотой үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд оршино.

3 дугаар зүйл

Зарчим

Энэхүү хэлэлцээрийн дагуу, Оролцогч улс ил тод, нийцтэй байх, хялбар, үр ашигтай, харилцан уялдаатай, стандартчилагдсан байх зарчмыг удирдлага болгож, хамтын ажиллагаагаа ахиулан ажиллана.

4 дүгээр зүйл

Ил тод, нийцтэй байх зарчмыг хангах арга хэмжээ

Оролцогч улс дараах зүйлийг хэрэгжүүлэхийг зорино:

1. Олон улсын худалдаатай холбогдох албан ёсны, эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн эх сурвалжаар дамжуулан дотоодын холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, техникийн мэдээллийг сонирхсон Оролцогч улсад үл ялгаварлах зарчмын дагуу төлбөргүй эсхүл бага зардлаар авах боломжийг олгож, холбогдох хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, техникийн мэдээллийн агуулгыг англи хэлээр хэвлэн нийтлэх;
2. Худалдаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж болох худалдааны шинэ хууль тогтоомж баталсан, эсхүл одоо үйлчилж буй хууль тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт оруулсан бол энэ тухайгаа Оролцогч бусад улс, Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗНК)-ын дарга нарын газарт мэдэгдэх;
3. Тарифын ангилал зэрэг импортын үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй холбоотой асуудлаар дотоодын хууль тогтоомж, захиргааны шийдвэрийн дагуу урьдчилсан шийдвэр гаргах механизмыг бий болгох;
4. Гааль болон холбогдох бусад байгууллагаас гаргасан олон улсын худалдаанд нөлөөлөхүйц шийдвэрийн эсрэг хуулийн дагуу, эсхүл захиргааны журмаар боломжит хугацаанд, боломжит зардлаар давж заалдах журмыг үл ялгаварлах зарчмыг баримтлан гаргах.

5 дугаар зүйл

Хялбар болон үр ашигтай байх зарчмыг хангах арга хэмжээ

Оролцогч улс нь:

1. Экспорт, импорттой холбогдуулан ногдуулдаг төлбөр, хураамжийн тоо, төрлийг багасган, нэгтгэж, үндэслэл бүхий болгоно:
 - (а)Төлбөр, хураамжийг зөвхөн тухайн экспорт, импорттой шууд холбогдуулан үзүүлсэн үйлчилгээнд ногдуулах бөгөөд үзүүлсэн үйлчилгээний жишиг зардлаас хэтрэхгүй байна.
 - (б)Оролцогч улс бүр төлбөр, хураамжаа нэгтгэх, тоо, төрлийг нь багасгах зорилгоор төлбөр, хураамжаа тогтмол хянана.

2. Экспорт, импортын мэдээлэл болон шаардлагатай бичиг баримтыг нэг удаа бүрдүүлэн өгөх боломжийг олгох нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллана.
3. Бараанд биет шалгалт хийх, эсхүл бүрдүүлсэн баримт бичгийг дахин хянах шаардлага үүсэхээс бусад тохиолдолд барааг, нэн ялангуяа түргэн муудах барааг импортлогч импортолсон даруй нэхэмжлэн авах боломжийг бий болгох зорилгоор ирэхээс нь өмнө бүрдүүлэлт хийх, шалгах журмыг бий болгоно.
4. Эрсдэлийг үнэлэх, эрсдэлийн удирдлагын журмыг тодорхой шатлалтайгаар бий болгоно.
5. Киотогийн конвенцын шинэчилсэн найруулга, Дэлхийн гаалийн байгууллагаас гаргасан холбогдох зөвлөмж зэрэг олон улсын стандартыг мөрдөх замаар дотоодын хууль тогтоомж, захиргааны шийдвэрийн дагуу тогтоосон экспорт, импортын журам, мэдээллийн шалгуурын төвөггүй байдал, тохиолдлыг хууль ёсны бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хамгийн бага түвшинд хүртэл бууруулан хялбаршуулна.
6. Гаалийн үйл ажиллагаанд автоматжуулалт, мэдээллийн технологийг ашиглах, экспортлогч, импортлогч нарт зориулан баримт бичгийн бүрдүүлэлт, татварын төлбөр хураамжийг цахимаар хийх, гаалийн байгууллагатай харилцах үйл явцыг хялбаршуулах зорилгоор цахим харилцааны бүтцийг бий болгохыг боломжийн хэмжээнд дэмжинэ.

6 дугаар зүйл

Харилцан уялдаатай, стандартчилагдсан байх зарчмыг хангах арга хэмжээ

Оролцогч улс нь:

1. Дэлхийн гаалийн байгууллагын ивээл дор боловсруулсан Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн шинэчилсэн хувилбарт суурилсан тарифын нэр, төрлийг тарифын зорилгоор ашиглана;
2. Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай Киотогийн конвенцын шинэчилсэн найруулгын зөвлөмж, стандартыг боломжийн хэмжээнд мөрдөж ажиллана;
3. Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 7 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай Дэлхийн худалдааны байгууллагын 1994 оны хэлэлцээрийг дагаж мөрдөнө.

7 дугаар зүйл

Хамтран ажиллах арга хэмжээ

Оролцогч улс нь:

1. Худалдаатай холбоотой шинэ болон нэмэлт, өөрчлөлт оруулж буй хууль тогтоомжийг хучин төгөлдөр болох, хэрэгжиж эхлэхээс нь өмнө санал өгөх боломжийг сонирхсон Оролцогч улс болон хувийн хэвшилд олгохыг зорино.
2. Гаалийн уялдаа холбоог сайжруулах, хууль ёсны худалдааг хөнгөвчлөх зорилгоор гаалийн мэдээлэл болон өгөгдлийг үр дүнтэй харилцан солилцох чиглэлээр хамтран ажиллахыг зорино.



8 дугаар зүйл

Дотоод үйл ажиллагааны журам

1. Сайд нарын зөвлөл энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хоёр жил тутамд хянана.
2. Байнгын хороо нь энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдан зохицуулах бөгөөд гаргасан зөвлөмжөө хянуулахаар Сайд нарын зөвлөлд хүргүүлнэ.
3. Байнгын хороо нь 8.2-т заасныг хэрэгжүүлэх зорилгоор, энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хянан, Байнгын хороонд тайлагнаж, шийдвэр гаргуулах бүхий гаалийн болон холбогдох бусад байгууллагын ажилтнуудаас бүрдсэн Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийг байгуулна.
4. Оролцогч улс бүр энэхүү хэлэлцээрийн хэрэгжилт болон үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг харилцан солилцох зэрэг энэхүү хэлэлцээрээр зохицуулсан аливаа асуудлаар өөр хоорондоо харилцах үйл ажиллагаагаа хялбарчлах зорилгоор нэг, эсхүл түүнээс дээш харилцах этгээдийг томилно. Харилцах этгээд өөрчлөгдвөл даруй мэдэгдэнэ.
5. АНДЭЗНК-ийн Нарийн бичгийн дарга нарын газар нь Худалдааг хөнгөвчлөх ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нарын газар байна.

9 дүгээр зүйл

Маргаан шийдвэрлэх

Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, хэрэглэхтэй холбогдон үүссэн аливаа маргааныг АНДХХ-ийн 21 дүгээр зүйлд заасан журам, механизмын дагуу шийдвэрлэнэ.

10 дугаар зүйл

Нэн буурай хөгжилтэй Оролцогч улсад үзүүлэх туслалцаа

Оролцогч улсууд нэн буурай хөгжилтэй Оролцогч улсыг тусгайлан анхаарч энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд нь шаардлагатай худалдааг хөнгөвчлөх чадавхыг нь бий болгох техникийн туслалцаа, хамтын ажиллагааны дэмжлэгийг үзүүлэх замаар мэдээлэл солилцох зорилго бүхий сургалтын хөтөлбөр, сургалт, семинар зэрэг хэрэгжих боломжтой арга хэмжээ болон бусад холбогдох үйл ажиллагааг боломжийн хэмжээнд авах зэргээр бодит үр ашиг хуртэх боломжийг олгоно. Нэн буурай хөгжилтэй Оролцогч улс энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавхыг олж авсны дараа энэхүү хэлэлцээрийг дагаж мөрдөнө.

11 дүгээр зүйл

Төгсгөлийн заалт

1. Оролцогч бүх улсын зөвшөөрлөөр энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
2. Энэхүү хэлэлцээрт нь хавсралт нэмж болох бөгөөд хавсралт нь хэлэлцээрийн салшгүй хэсэг байна. Энэхүү хэлэлцээрийг эш татсан аливаа эшлэлд энэхүү хэлэлцээрийн хавсралтууд багтсан гэж үзнэ.
3. Оролцогч улс энэхүү хэлэлцээрээр харилцан тохиролцсон үүргээ биелүүлэхэд шаардлагатай зохих арга хэмжээг авна.
4. Оролцогч улс энэхүү хэлэлцээрийн аль нэгэн заалттай холбогдуулан ямар нэг тайлбар хийхгүй.



5. Энэхүү хэлэлцээр нь хэлэлцээрт гарын үсэг зурсан бүх Засгийн газар хэлэлцээрийг соёрхон баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн батламж жуух бичгээ АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газарт хадгалуулснаар хүчин төгөлдөр болно. АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газар батламж жуух бичгийн баталгаат хуулбарыг Оролцогч улс бүрд нэн даруй хүргүүлнэ. Хэлэлцээрт гарын үсэг зурсан Засгийн газар энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш зургаан сарын дотор соёрхон баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн батламж жуух бичгээ хадгалуулна.

6. АНДХХ-ийн 11 болон 26 дугаар зүйлийн дагуу энэхүү хэлэлцээр нь АНДХХ-ийн Хавсралт III-А болох бөгөөд хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.

ДЭЭРХИЙГ НОТОЛЖ, гарын үсэг зурсан улсуудын дор дурдсан бүрэн эрхт төлөөлөгчид тус тусын Засгийн газраа төлөөлж энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав. Хэлэлцээрийг хоёр мянга есөн оны арван хоёрдугаар сарын арван тавны өдөр Сөүл хотноо англи хэлээр нэг хувь үйлдэв.



3. АЗИ, НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ОРОЛЦОГЧ УЛС ХООРОНД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДААГ ИДЭВХЖҮҮЛЭХ, ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

(цаашид “энэхүү хэлэлцээр” гэх)

Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улсын Засгийн газар, Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (АНДХХ)-ийн Оролцогч улсууд (цаашид “Оролцогч улс” гэх);

Үйлчилгээний худалдааны ач холбогдол Оролцогч улсын хувьд нэмэгдэж буйг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ**;

Хамтын зүтгэлээр үйлчилгээний худалдааг чөлөөлөх, АНДХХ-ийн хүрээнд худалдаа, хөрөнгө оруулалтын урсгалыг идэвхжүүлэх замаар Оролцогч бүх улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийг тогтворжуулахын чухлыг **НОТОЛЖ**;

Оролцогч улс хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаа нь тэдний хооронд үйлчилгээний худалдааг дэмжин, бэхжүүлэх зорилго бүхий үйлчилгээний худалдааг чөлөөтэй эрхлэх орчин бүрдүүлэхийг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ**;

Энэтхэг Улсын Гао хотноо 2007 оны 10 дугаар сарын 26-ны өдөр болсон Сайд нарын зөвлөлийн хоёр дахь удаагийн чуулга уулзалтын үеэр баталсан АНДХХ-ийн сайд нарын тунхаглалаар яриа хэлэлцээг тарифын бус арга хэмжээ, худалдааг хөнгөвчлөх, үйлчилгээ болон хөрөнгө оруулалт зэрэг салбараар өргөжүүлэх аргачлалыг даруй батлах чиглэлийг Байнгын хороонд өгснийг **САНАЖ**;

Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээр (цаашид “ҮХЕХ” гэх)-ийн дүрэм, зарчмын дагуу хүлээсэн үүрэг амлалтаа **ДАХИН ТЭМДЭГЛЭЖ**;

Эдийн засгийн интеграцын тухай ҮХЕХ-ийн V зүйлийг **ҮНДЭСЛЭЖ**;

Оролцогч улс харилцан бие биедээ үйлчилгээний худалдааны хөнгөлөлт үзүүлэхээ **НОТОЛЖ**;

Үндэсний бодлогын зорилтоо хэрэгжүүлэх зорилгоор Оролцогч улсын өөрийн нутаг дэвсгэр дэх үйлчилгээний нийлүүлэлтийг зохицуулах, зохицуулалтын шинэ арга хэмжээ авах эрхийг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ**;

Оролцогч улсууд худалдааг чөлөөлөхөд дөхөм болох хилийн болон хилийн бус арга хэмжээтэй холбоотой хамтын ажиллагааны бусад салбарыг эрэлхийлнэ гэж заасан АНДХХ-ийн 11 дүгээр зүйл, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай АНДХХ-ийн 26 дугаар зүйлийг тус тус **ҮНДЭСЛЭН**;

Дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Тодорхойлолт

Энэхүү хэлэлцээрийн зорилгоор:

- (а) “хуулийн этгээд” гэж холбогдох хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, эсхүл бусад хэлбэрээр зохион байгуулагдсан ашгийн болон бусад төрлийн хувийн болон төрийн өмчит корпорац, итгэлцэл дээр суурилсан нэгж, нөхөрлөл, хамтарсан үйлдвэр, ганц хүний өмчлөл бүхий хуулийн этгээд, эсхүл хоршоо зэргийг хэлнэ.

- (b) “этгээд” гэж хувь хүн, эсхүл хуулийн этгээдийг хэлнэ;
- (c) хуулийн этгээдийн:
 - (i) нийт гаргасан хувьцааны 50-иас дээш хувийг тухайн Оролцогч улсын этгээд эзэмшдэг бол Оролцогч улсын этгээдийн “өмчлөлтэй” гэж;
 - (ii) хэрэв тухайн этгээд нь захирлуудын дийлэнх хувийг томилох, эсхүл тэдгээрийн үйл ажиллагааг хуулийн дагуу удирдах эрх мэдэлтэй бол Оролцогч улсын этгээдийн “удирдлагад байдаг” гэж үзнэ.
- (d) “Оролцогч нөгөө улсын хуулийн этгээд” гэж:
 - (i) тухайн Оролцогч улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, эсхүл бусад хэлбэрээр зохион байгуулагдсан бөгөөд тухайн Оролцогч улсын, эсхүл Оролцогч өөр нэг улсын нутаг дэвсгэрт бизнесийн дорвитой үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийг; эсхүл
 - (ii) үйлчилгээ үзүүлж буй улсын нутаг дэвсгэр дээрх хуулийн этгээдээрээ дамжуулан үйлчилгээ явуулдаг бөгөөд дор дурдсан этгээдийн өмчлөл, удирдлага дор байдаг хуулийн этгээдийг хэлнэ:
 - 1. тухайн Оролцогч улсын хувь хүн; эсхүл
 - 2. (i) заалтад дурдсан Оролцогч өөр нэг улсын хуулийн этгээд.
- (e) “Оролцогч улсын хувь хүн” гэж тухайн Оролцогч улсын хуулийн дагуу тухайн улсын иргэн болох хувь хүнийг хэлнэ;
- (f) “арга хэмжээ” гэж тухайн Оролцогч улсаас авч хэрэгжүүлж буй хууль, дүрэм, журам, шийдвэр, захиргааны арга хэмжээ, эсхүл өөр бусад хэлбэрээрх аливаа арга хэмжээг хэлнэ;
- (g) “үйлчилгээний худалдаа” гэж:
 - (i) Оролцогч нэг улсын нутаг дэвсгэрээс Оролцогч өөр нэг улсын нутаг дэвсгэрт нийлүүлсэн;
 - (ii) Оролцогч нэг улсын нутаг дэвсгэр дээр Оролцогч өөр нэг улсын үйлчилгээ хэрэглэгчид үзүүлсэн;
 - (iii) Оролцогч аль нэг улсын үйлчилгээ ханган нийлүүлэгчийн Оролцогч өөр нэг улсын нутаг дэвсгэр дэх хуулийн этгээдээрээ дамжуулан үзүүлсэн;
 - (iv) Оролцогч аль нэг улсын нутаг дэвсгэр дээр Оролцогч аль нэг улсын үйлчилгээ ханган нийлүүлэгчийн Оролцогч улсын хувь хүнээр дамжуулан үзүүлсэн үйлчилгээг тус тус хэлнэ.
- (h) “Оролцогч улсаас авсан үйлчилгээний худалдаанд нөлөөлөх арга хэмжээ” гэж дор дурдсан үйл ажиллагаатай холбогдох арга хэмжээг хэлнэ:
 - (i) үйлчилгээний худалдан авалт, төлбөр, эсхүл ашиглалт;
 - (ii) Оролцогч тухайн улсаас олон нийтэд нийтээр нь үзүүлэхийг шаарддаг үйлчилгээний нийлүүлэлттэй холбогдон үүсэх ашиглалт, эсхүл хүртээмж;



- (iii) Оролцогч өөр нэг улсын нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий Оролцогч аль нэг улсын этгээдийн оршин суух асуудал, хуулийн этгээдийн байршил.
- (i) “үйлчилгээ” гэдэгт Засгийн газар бүрэн эрхийнхээ хүрээнд үзүүлдэг үйлчилгээнээс бусад салбарт хийгдэж буй аливаа үйлчилгээг хамруулна;
- (j) “үйлчилгээ үзүүлэгч” гэж үйлчилгээ үзүүлж буй аливаа этгээд¹ийг хэлнэ;
- (k) “үйлчилгээ үзүүлэх” гэдэгт үйлчилгээний үйлдвэрлэл, түгээлт, маркетинг, борлуулалт болон хүргэлтийг хамруулна;
- (l) “Нарийн бичгийн дарга нарын газар” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗНК) - ын Нарийн бичгийн дарга нарын газрын хэлнэ.

2 дугаар зүйл

Хамрах хүрээ

1. Энэхүү хэлэлцээр нь Оролцогч улсаас авсан үйлчилгээний худалдаанд нөлөөлөх арга хэмжээнд үйлчилнэ.

2. Энэхүү хэлэлцээр нь дор дурдсан зүйлд үл хамаарна:

- (a) Засгийн газрын худалдан авалт;
- (b) Засгийн газрын дэмжлэгтэй зээл, баталгаа болон даатгал зэрэг татаас, эсхүл тэтгэлэг, эсхүл эдгээрийг хүлээн авах, эсхүл үргэлжлүүлэн хүлээн авахтай холбогдох аливаа нөхцөл;
- (c) арилжааны бус зорилгоор, эсхүл үйлчилгээ үзүүлэгч бусад ханган нийлүүлэгчтэй өрсөлдөх зорилгогүйгээр засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд нийлүүлж буй үйлчилгээ;
- (d) Оролцогч улсын хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх зорилго бүхий хувь хүнд нөлөөлөх арга хэмжээ;
- (e) иргэншил, байнга оршин суух, эсхүл хөдөлмөр эрхлэхтэй холбоотой арга хэмжээ.

3. Оролцогч бусад улсын хувь хүнийг нутаг дэвсгэртээ нэвтрүүлэх, эсхүл түр оршин суухтай нь холбогдуулан хилийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, хувь хүний хил нэвтрэх хөдөлгөөнийг зохицуулах зэрэг арга хэмжээг Оролцогч улсын зүгээс авахад энэхүү хэлэлцээрийн аль ч заалт саад учруулахгүй. Гэхдээ ийм арга хэмжээг Оролцогч бусад улсын энэхүү хэлэлцээр, эсхүл дараа дараачийн яриа хэлэлцээний дагуу авч хэрэгжүүлэх тусгай үүрэг амлалтаас хүртэх аливаа давуу эрх, үр ашгийг бууруулах, цуцлах байдлаар хэрэглэхгүй. ²

¹Үйлчилгээг тухайн хуулийн этгээд шууд нийлүүлээгүй, харин уг үйлчилгээг үзүүлж буй тухайн нутаг дэвсгэр дээрх салбар, эсхүл төлөөлөгчийн газар зэрэг худалдааны төлөөллийн бусад хэлбэрээр дамжуулан нийлүүлсэн тохиолдолд тус үйлчилгээг нийлүүлэгч нь ямар ч тохиолдолд энэхүү хэлэлцээрээр олгодог хөнгөлөлтийг эдэлнэ. Энэхүү хөнгөлөлтийг уг үйлчилгээг нийлүүлсэн тухайн нутаг дэвсгэр дэх этгээдэд үзүүлэх бөгөөд уг үйлчилгээг нийлүүлсэн нутаг дэвсгэрээс гадна байгаа тухайн нийлүүлэгчийн холбогдох бусад нэгжид үзүүлэхгүй.

²Оролцогч зарим улсын хувь хүнээс шаардаагүй боловч Оролцогч тодорхой улсын хувь хүнд тавьж буй визийн шаардлагыг тусгай үүрэг амлалтаас хүртэх аливаа давуу эрх, үр ашгийг бууруулсан, цуцалсан гэж үзэхгүй.

3 дугаар зүйл

Зорилго

Оролцогч улс энэхүү хэлэлцээрийн дагуу дараах зорилгыг хэрэгжүүлнэ:

- (a) өрсөлдөх чадвар, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Оролцогч улс хооронд үйлчилгээний салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэх, үйлчилгээ ханган нийлүүлэгчдийнхээ Оролцогч улс хоорондын болон гаднах үйлчилгээний үйлдвэрлэл, нийлүүлэлт, түгээлтийн чадавхыг төрөлжүүлэх;
- (b) Оролцогч улс хооронд үйлчилгээний худалдааг хөнгөвчлөх зорилгоор хязгаарлалтыг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах;
- (c) чөлөөлөлтийн хамрах хүрээг өргөтгөх, чанарыг сайжруулах замаар үйлчилгээний худалдааг ҮХЕХ-ээс илүү чөлөөлөх.

4 дүгээр зүйл

Хамтын ажиллагааны салбар

1. Оролцогч бүх улс энэхүү хэлэлцээрийн дагуу хамтын ажиллагааны үйл ажиллагаанд оролцоно.

2. Оролцогч улс үйлчилгээний салбарт хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны хүч чармайлтыг нэмэгдүүлэн, бэхжүүлж, уг хамтын ажиллагааны хүрээнд хамрагдаагүй салбарын хамтын ажиллагааг дараах замаар хөгжүүлнэ. Үүнд:

- (a) дэд бүтцийн байгууламжийг байгуулах, эсхүл сайжруулах;
- (b) хамтарсан үйлдвэрлэл, маркетинг болон худалдан авалтын үйл ажиллагаа;
- (c) судалгаа, хөгжүүлэлт; болон
- (d) мэдээлэл солилцоо;

3. Оролцогч улс хамтын ажиллагааны салбараа тодорхойлж, хамтын ажиллагааны шинж чанар, хамрах хүрээг нарийвчлан заасан үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр, харилцан ойлголцлын баримт бичгийг боловсруулна.

5 дугаар зүйл

Худалдааг чөлөөлөх

3 дугаар зүйлийн 3(c) хэсгийн дагуу, Оролцогч улс үйлчилгээний худалдааг олон тооны салбарт дараах байдлаар чөлөөлнө:

- (a) Оролцогч улс хооронд хэрэгжиж буй ялгавартай арга хэмжээ, зах зээлд нэвтрэх хязгаарлалтыг аажмаар бууруулах;
- (b) шинээр ялгавартай арга хэмжээ, зах зээлд нэвтрэх хязгаарлалт нэвтрүүлэхээс татгалзах.

6 дугаар зүйл

Тусгайлан анхаарах

1. Энэхүү хэлэлцээрийн дагуу гаргаж өгөх бүх тусгай үүрэг амлалтын хуваарь, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хүргүүлэх, хэрэгжүүлэх асуудлаар Нэн буурай хөгжилтэй Оролцогч улсад уян хатан хандана. Оролцогч улс өөрийн тусгай үүрэг, амлалтын хуваарь, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөгөөрөө эдгээр улсад зориулан тусгай хөнгөлөлт олгох асуудлыг боломжтой үедээ судлан үзнэ.



2. Оролцогч бусад улстай үйлчилгээний худалдааны харилцаагаа өргөжүүлэхэд чиглэсэн техникийн туслалцаа авах, хамтын ажиллагааны тохиролцоо хийх, энэхүү хэлэлцээрийн бодит үр ашгийг хүртэх тухай Нэн буурай хөгжилтэй Оролцогч улсаас гаргасан хүсэлтийг Оролцогч улс тусгайлан анхаарна.

3. Энэ зүйлийн 1 дүгээр хэсгийн дагуу Шри Ланка Улсыг мөн адил тусгайлан анхаарна.

7 дугаар зүйл

Тусгай үүрэг, амлалтын талаарх яриа хэлэлцээ

1. Оролцогч улс үйлчилгээний тодорхой салбарын худалдаанд нөлөөлөх арга хэмжээний талаар яриа хэлэлцээ хийнэ. Хэрэв Оролцогч улс нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн улс бол ийм яриа хэлэлцээ нь ҮХЕХ-ийн Оролцогч улс бүрийн тусгай үүрэг амлалтын хуваарьт тусгагдсан үүрэг амлалтаас илүү үүрэг амлалтыг өгөхөд чиглэнэ. Тус яриа хэлэлцээний үр дүнг Оролцогч улс бүрийн тусгай үүрэг амлалтын хуваарьт тусгана. Уг хуваарийг энэхүү хэлэлцээрт хавсаргах бөгөөд хэлэлцээрийн салшгүй хэсэг гэж үзнэ.

2. Өөрөөр тохиролцоогүй бол 6.1 дэх хэсгийг харгалзан үзсэний үндсэн дээр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тусгай үүрэг амлалтыг Нэн тааламжтай үндэстний нөхцөл (НТҮН)-ийн дагуу Оролцогч бүх улсад өгнө.

3. Оролцогч улс ҮХЕХ-ийн XVI-XVIII болон XX зүйлийг тусгай үүрэг амлалт өгөх зорилгоор хэрэглэнэ.

8 дугаар зүйл

Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээр

Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол, Оролцогч улс 13 дугаар зүйлийн дагуу хэлэлцээрийг хянасны үндсэн дээр хэлэлцэн тохиролцсон аливаа тохиролцоог харгалзан, тухайн Оролцогч улс Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн мөн эсэхээс үл хамаарч, үйлчилгээний худалдаатай холбоотой болон түүнд үйлчлэх Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрийг даган мөрдөхөө үүгээр дахин нотолж, хүлээн зөвшөөрч байна.

9 дүгээр зүйл

Үл хамаарах нөхцөл

Энэхүү хэлэлцээр болон түүнээс үүдэн гарах үйлчилгээний худалдаатай холбоотой аливаа тохиролцоо, хэлэлцээр, харилцан ойлголцлын баримт бичигт АНДХХ-ийн 35 дугаар зүйл үйлчилнэ.

10 дугаар зүйл

Маргаан шийдвэрлэх

Энэхүү хэлэлцээрийн дагуу маргаан шийдвэрлэх тусгай механизм байгуулаагүй бол АНДХХ-ийн 21 дүгээр зүйл энэхүү хэлэлцээрт үйлчилнэ.

11 дүгээр зүйл

Давуу эрх олгохоос татгалзах

Урьдчилан мэдэгдэл хүргүүлсэн, зөвлөлдсөн эсэхийг харгалзан үзсэний үндсэн дээр, Оролцогч улс дараах тохиолдолд энэхүү хэлэлцээрийн дагуу давуу эрх олгохоос татгалзаж болно:

- (a) үйлчилгээг энэхүү хэлэлцээрийн Оролцогч бус улсын нутаг дэвсгэрээс, эсхүл Оролцогч бус улсын нутаг дэвсгэрт нийлүүлсэн болохыг тогтоосон бол тухайн үйлчилгээнд;
- (b) Далайн тээврийн үйлчилгээг дор дурдсанаар нийлүүлсэн болохыг тогтоосон бол:
 - (i) Оролцогч бус улсын хуулийн дагуу бүртгэлтэй усан онгоцоор; болон
 - (ii) Оролцогч бус улсын этгээдийн ажилуулж буй, эсхүл бүхлээр нь, эсхүл зарим хэсгийг нь ашиглаж буй онгоцоор; эсхүл тухайн улсын нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлдэг өөр улсад бүртгэлтэй онгоцоор нийлүүлсэн болох нь тогтоогдсон бол.
- (c) Оролцогч өөр нэг улсын үйлчилгээ ханган нийлүүлэгчид, дараах тохиолдолд:
 - (i) үйлчилгээ ханган нийлүүлэгч хувь хүн нь Оролцогч бусад улсын иргэн биш болохыг тогтоосон бол;
 - (ii) үйлчилгээ ханган нийлүүлэгч хуулийн этгээд нь энэхүү хэлэлцээрээр тодорхойлсон Оролцогч өөр нэг улсын хуулийн этгээд биш болохыг тогтоосон бол.

12 дугаар зүйл

Нэмэлт хэлэлцээр болон тохиролцоо

Энэхүү хэлэлцээр болон бусад хэлэлцээр, тохиролцоо, үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрийн дараа дараачийн яриа хэлэлцээнээс үүдэн гарсан тодорхой үүрэг амлалтын хуваарь, харилцан ойлголцлын баримт бичиг нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.

13 дугаар зүйл

Бусад хэлэлцээр

1. Энэхүү хэлэлцээр, эсхүл хэлэлцээрийн дагуу авсан аливаа арга хэмжээ нь Оролцогч улсын нэгдэн орсон, хүчин төгөлдөр хэлэлцээрээр хүлээсэн эрх, үүргийг хөндөхгүй.
2. Энэхүү хэлэлцээрийн аль ч заалт тус хэлэлцээрийн зарчим, зорилго, нөхцөлтэй үл зөрчилдөх өөр хэлэлцээр байгуулах Оролцогч улсын эрхийг хөндөхгүй.
3. Оролцогч улс энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан даруй үйлчилгээний худалдаатай холбоотой, эсхүл нөлөөлөхүйц гарын үсэг зурсан бусад хэлэлцээрийн талаар Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

14 дүгээр зүйл

Дотоод үйл ажиллагааны журам

1. Сайд нарын зөвлөл энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хоёр жил тутамд хянана.
2. Байнгын хороо энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хянах, удирдах, яриа хэлэлцээг зохион байгуулах зэргээр, хэлэлцээрийн хэтийн зорилгыг тодорхойлох, үйл ажиллагааг нь хөнгөвчлөх чиг үүрэгтэй.



3. Байнгын хороо нь энэ зүйлийн 2 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор, үйлчилгээний худалдааны тодорхой салбар болон дэд салбарын ахлах ажилтан, шинжээчээс бүрдсэн Үйлчилгээний ажлын хэсгийг байгуулна.

4. Нарийн бичгийн дарга нарын газар нь Сайд нарын зөвлөл, Байнгын хороо, Үйлчилгээний ажлын хэсэгт энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хянах, удирдан, зохион байгуулах зэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зэргээр туслалцаа үзүүлнэ.

15 дугаар зүйл

Нэмэлт, өөрчлөлт

1. Энэ зүйлийн 2 дугаар хэсгийг харгалзан үзсэний үндсэн дээр, Оролцогч бүх улсын зөвшөөрлийн дагуу энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь Оролцогч бүх улс хүлээн зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болно.

2. Хуваарьт тусгасан аливаа үүрэг амлалтыг өөрчлөх, буцаан авах асуудлыг ҮХЕХ-ийн 21 дүгээр зүйлийн дагуу *mutatis mutandis* (зохих өөрчлөлттэйгөөр) зарчмын дагуу зохицуулна. Үйлчилгээний худалдааны зөвлөл гэснийг АНДХХ-ийн Байнгын хороо гэж үзнэ. ХХI зүйлийн 3 болон 4 дүгээр хэсэгт заасан арбитр гэснийг маргааныг Оролцогч улсын гуравны хоёрын зөвшөөрлөөр шийдвэрлэж болох АНДХХ-ийн Байнгын хороо гэж үзнэ.

16 дугаар зүйл

Хүлээн зөвшөөрөх

1. Үйлчилгээ ханган нийлүүлэгчид эрх, тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгох стандарт, шалгуурыг хангах зорилгоор, Оролцогч улс Оролцогч өөр нэг улсад эзэмшсэн боловсрол, эсхүл туршлага, хангасан шалгуур, эсхүл олгосон тусгай зөвшөөрөл, гэрчилгээг хүлээн зөвшөөрч болно.

2. Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа, Оролцогч улсын зохицуулалт бүхий үйлчилгээний аливаа салбарт Оролцогч өөр нэг улсаас бичгээр хүсэлт гаргавал Оролцогч улс зохиолдолд өөрийн холбогдох мэргэжлийн байгууллагыг мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл, түр зөвшөөрөл, гэрчилгээ олгоход мөрдөх харилцан хүлээн зөвшөөрөх боломж бүхий стандарт, шалгуурыг боловсруулах яриа хэлэлцээ хийхийг дэмжинэ.

17 дугаар зүйл

Харилцах этгээд

1. Хэлэлцээрийн хэрэгжилт, үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг солилцох зэрэг энэхүү хэлэлцээрийн үйлчлэх хүрээнд хамаарах аливаа асуудлаар Оролцогч улс хооронд харилцах үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор харилцах этгээдийг томилно.

2. Хүсэлтийг хүлээн авч буй Оролцогч талын харилцах этгээд нь Оролцогч аль нэг талын хүсэлтийн дагуу тухайн асуудлыг хариуцсан байгууллага, эсхүл албан тушаалтныг тогтоон, хүсэлт гаргасан Оролцогч талтай харилцах үйл ажиллагааг хөнгөвчлөхөд дэмжлэг үзүүлнэ.

18 дугаар зүйл

Төгсгөлийн заалт

1. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд үүссэн боловч энэхүү хэлэлцээрээр тусгайлан зохицуулаагүй аливаа асуудалд ҮХЕХ-ийн нэр томъёо, тодорхойлолт болон бусад зохицуулалтыг хэрэглэнэ.

2. Энэхүү хэлэлцээр нь хэлэлцээрт гарын үсэг зурсан бүх Засгийн газар хэлэлцээрийг соёрхон баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн батламж жуух бичгээ АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газарт хадгалуулснаар хүчин төгөлдөр болно. АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газар батламж жуух бичгийн баталгаат хуулбарыг Оролцогч улс бүрд нэн даруй хүргүүлнэ. Хэлэлцээрт гарын үсэг зурсан Засгийн газар энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш зургаан сарын дотор соёрхон баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн батламж жуух бичгээ хадгалуулна.

3. АНДХХ-ийн 11 болон 26 дугаар зүйлийн дагуу энэхүү хэлэлцээр нь АНДХХ-ийн Хавсралт III-B хэсэг болох бөгөөд хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.

ДЭЭРХИЙГ НОТОЛЖ, дор гарын үсэг зурсан бүрэн эрхт төлөөлөгчид АНДХХ-ийн Оролцогч улс хооронд үйлчилгээний худалдааг идэвхжүүлэх, чөлөөлөх тухай ерөнхий хэлэлцээрт гарын үсэг зурав.

Хэлэлцээрийг хоёр мянга арван нэгэн оны наймдугаар сарын хорин дөрөвний өдөр англи хэлээр найман хувь үйлдэв, эх тус бүр нь адил хүчинтэй байна.

4. АЗИ, НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ОРОЛЦОГЧ УЛС ХООРОНД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

(цаашид “энэхүү хэлэлцээр” гэх)

Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс болон Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улсын Засгийн газар, Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (АНДХХ)-ийн оролцогч улсууд (цаашид “Оролцогч улс” гэх);

АНДХХ-ийн хүрээнд хамтын зүтгэлээр худалдаа, хөрөнгө оруулалтын урсгалыг идэвхжүүлж, худалдааг чөлөөлөх замаар Оролцогч бүх улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийг тогтворжуулахын чухлыг **НОТОЛЖ**;

Хөрөнгө оруулалт нь эдийн засаг, аж үйлдвэр, дэд бүтэц болон технологийн хөгжлийн тогтмол өсөлтийг тэтгэх санхүүгийн болон мэдлэгийн чухал эх үүсвэр гэдгийг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ**;

Оролцогч улсад оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, тогтвортой хэмжээнд барих арга хэмжээ авах шаардлагатай байгааг **НОТОЛЖ**;

Энэтхэг Улсын Гао хотноо 2007 оны 10 дугаар сарын 26-ны өдөр болсон Сайд нарын зөвлөлийн хоёр дахь удаагийн чуулга уулзалтын үеэр баталсан АНДХХ-ийн сайд нарын тунхаглалаар яриа хэлэлцээг тарифын бус арга хэмжээ, худалдааг хөнгөвчлөх, үйлчилгээ болон хөрөнгө оруулалт зэрэг салбараар өргөжүүлэх аргачлалыг даруй батлах чиглэлийг Байнгын хороонд өгснийг **САНАЖ**;

Илүү чөлөөтэй, ил тод хөрөнгө оруулалтын орчин бий болгох замаар Оролцогч улсын байр суурийг хөрөнгө оруулалт хүлээн авах, өрсөлдөх чадвар бүхий улсын хувиар илүү бэхжүүлэхээр **ШИЙДЭЖ**;

Оролцогч улсууд худалдааг чөлөөлөхөд дөхөм болох хилийн болон хилийн бус арга хэмжээтэй холбоотой хамтын ажиллагааны бусад салбарыг эрэлхийлнэ гэж заасан АНДХХ-ийн 11 дүгээр зүйл, хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай АНДХХ-ийн 26 дугаар зүйлийг тус тус **ҮНДЭСЛЭН**;

Дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:



1 дүгээр зүйл

Тодорхойлолт

Энэхүү хэлэлцээрийн хүрээнд:

1. “АНДХХ-ийн хөрөнгө оруулагч” гэж:

- (a) Оролцогч улсын холбогдох хуулийн дагуу тухайн улсын иргэншилтэй хувь хүн; эсхүл
- (b) Оролцогч улсын холбогдох хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, эсхүл бусад хэлбэрээр зохион байгуулагдсан, ашгийн болон бусад төрлийн хувийн болон төрийн өмчит, корпорац, итгэлцэл дээр суурилсан нэгж, нөхөрлөл, хамтарсан үйлдвэр, ганц хүний өмчлөл бүхий хуулийн этгээд, эсхүл хоршоо зэрэг хуулийн этгээд;
- (c) Оролцогч улсын холбогдох хуулийн дагуу байгуулагдсан, эсхүл бусад хэлбэрээр зохион байгуулагдсан, ашгийн болон бусад төрлийн корпорац, итгэлцэл дээр суурилсан нэгж, нөхөрлөл, хамтарсан үйлдвэр, ганц хүний өмчлөл бүхий хуулийн этгээд, эсхүл хоршоо зэрэг дээрх (a) - (b) хэсэгт заасан хувь хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бус өмчлөл, эсхүл удирдлагад байдаг хуулийн этгээдийг хэлнэ.

2(a). “Хөрөнгө оруулалт” гэж АНДХХ-ийн хөрөнгө оруулагчийн Оролцогч улсын хуулийн дагуу тухайн улсын нутаг дэвсгэрт оруулсан, эсхүл олж авсан бүх төрлийн хөрөнгийг ойлгох бөгөөд дор дурдсан хөрөнгөөр хязгаарлагдахгүй:

- (i) хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгө болон үл хөдлөх эд хөрөнгийн ипотекийн зээл, барьцааны эрх, зээлийн барьцаа;
 - (ii) хувьцаа, үнэт цаас, баталгаагүй бонд болон компанид оролцох адил хэлбэр;
 - (iii) бонд, зээл, зээлийн бусад хэрэгсэл;
 - (iv) санхүүгийн үнэ цэнэ бүхий гэрээний дагуух аливаа үйл ажиллагаа, эсхүл мөнгөний эрх;
 - (v) хөрөнгө оруулалт хүлээн авч буй талын хууль тогтоомжоор хамгаалагдсан оюуны өмчийн эрх, гүүдвил, техникийн үйл ажиллагаа болон ноу-хау;
 - (vi) хууль болон гэрээний дагуух концессын эрх, түүний дотор газрын тос болон бусад эрдэс баялаг, бусад байгалийн нөөцийн хайгуул, олборлолт, ашиглалтын концесс;
- (b) 1 дүгээр хэсгийн зорилгоор, хөрөнгө оруулалт хийсэн мөнгөн орлогыг хөрөнгө оруулалтад тооцох бөгөөд, хөрөнгө оруулалт хэлбэрээр хийсэн эд хөрөнгийн хэлбэр өөрчлөгдсөн, түүгээр дахин хөрөнгө оруулсан бол тэдгээрийг хөрөнгө оруулалт гэж тооцно.

3. “Орлого” гэж хөрөнгө оруулалтын үр дүнд олсон мөнгөн болон мөнгөн бус дүн, нэн ялангуяа ашиг, хөрөнгийн өсөлтөөс олсон ашиг, ногдол ашиг, роялти, эсхүл оюуны өмчийн эрхтэй холбогдох төлбөр болон бусад бүх төрлийн хураамжийг хэлнэ.

4. “Нарийн бичгийн дарга нарын газар” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗНК)-ын Нарийн бичгийн дарга нарын газрыг хэлнэ.

2 дугаар зүйл

Зорилго

Энэхүү хэлэлцээр нь дараах зорилготой:

- (a) Оролцогч улсад оруулах хөрөнгө оруулалтын урсгалыг дорвитой нэмэгдүүлэх;
- (b) Оролцогч улсыг хөрөнгө оруулалт татах таатай орчин болоход нь хамтран дэмжлэг үзүүлэх;
- (c) Оролцогч улсын эдийн засгийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, бэхжүүлэх;
- (d) Оролцогч улсын хөрөнгө оруулалтын урсгалыг сааруулж, хөрөнгө оруулалтын төслийн үйл ажиллагаанд саад учруулж болохуйц хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, нөхцөл байдлыг арилгах, эсхүл үе шаттайгаар бууруулах;
- (e) Оролцогч бүх улс хооронд хөрөнгө оруулалтын уялдуулсан дэглэм бий болгох зорилгоор тууштай хичээн ажиллах;
- (f) Оролцогч улс хооронд технологийн дамжуулалт, хөрөнгө оруулалтын чөлөөтэй урсгалыг дэмжих.

3 дугаар зүйл

Хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөө

1. Энэхүү хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтийг хангах хүрээнд, Оролцогч улс дор дурдсан хөтөлбөрийг тогтоосон хугацааны дотор хамтран хөгжүүлж, хэрэгжүүлэх зорилгоор яриа хэлэлцээг Байнгын хорооноос тогтоосон товоос хэтрүүлэхгүйгээр эхлүүлнэ.

- (a) Хуваарь I - т заасан хамтын ажиллагааны болон хөнгөвчлөх хөтөлбөр;
- (b) Хуваарь II - т заасан идэвхжүүлэх болон мэдлэг олгох хөтөлбөр;
- (c) Хуваарь III - т заасан чөлөөлөх хөтөлбөр; болон
- (d) Хуваарь IV - т заасан хамгаалалтын хөтөлбөр.

2. Оролцогч улс төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан Байнгын хорооноос товлосон хугацаанд хүргүүлнэ.

3. Үйл ажиллагааны төлөвлөгөөг энэхүү хэлэлцээрийн зорилгод нийцэж буй эсэхийг Байнгын хороогоор хэлэлцүүлсний дараа, Сайд нарын зөвлөлөөр хоёр жил тутамд хянуулна.

4 дүгээр зүйл

Ил тод байдал

1. Оролцогч улс энэхүү хэлэлцээрийн үйл ажиллагаанд хамаарах, эсхүл нөлөөлөх бүх хууль тогтоомж, журам, нийтээр дагаж мөрдөх захиргааны шийдвэрийг Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан Байнгын хороонд хүргүүлнэ. Оролцогч улсын нэгдэн орсон



хөрөнгө оруулалтад хамаарах, эсхүл нөлөөлөх олон улсын гэрээнд энэ хэсэг мөн адил үйлчилнэ.

2. Оролцогч улс энэхүү хэлэлцээрийн дагуу өгсөн үүрэг амлалтад нь, эсхүл хөрөнгө оруулалтад нөлөөлөх энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан, эсхүл шинээр баталсан тохиолдолд Байнгын хороонд Нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан нэн даруй, дор хаяж жил бүр мэдэгдэнэ.

3. Энэхүү хэлэлцээрийн аль ч заалт нууцын зэрэглэлтэй мэдээллийг гаргаж өгөх, ил болгосноор хууль сахиулах үйл ажиллагаанд саад учруулах, эсхүл олон нийтийн эрх ашигтай зөрчилдөх, эсхүл олон нийтийн болон хувийн аж ахуйн нэгжийн хууль ёсны худалдааны ашиг сонирхлыг хөндөхүйц мэдээллийг ил болгохыг Оролцогч улсаас шаардахгүй.

5 дугаар зүйл

Үл хамаарах ерөнхий нөхцөл

Адил нөхцөл давамгайлж буй Оролцогч улс хооронд үзэмжээрээ эсхүл шударга бусаар ялгаварлан хандахгүй байх, эсхүл хөрөнгө оруулалтад далд байдлаар хязгаарлалт хийхгүй байх шаардлагыг хангасан дараах арга хэмжээг баталж, хэрэгжүүлэхэд саад болох байдлаар энэхүү хэлэлцээрийг тайлбарлахгүй:

1. үндэсний аюулгүй байдал, олон нийтийн ёс суртахуун, нийтийн дэг журмыг сахин хамгаалах³, хүн, амьтан, ургамлын амьдрал, эрүүл мэнд, урлаг, түүх, археологийн үнэт зүйлийг хамгаалах зорилгоор авах шаардлагатай гэж үзсэн аливаа арга хэмжээ;
2. Оролцогч улсын хөрөнгө оруулагч, эсхүл хөрөнгө оруулалтад шууд татварыг тэгш, үр ашигтай ногдуулах, эсхүл хураах зорилго бүхий аливаа арга хэмжээ;
3. Энэхүү хэлэлцээрийн заалттай үл нийцэх хууль тогтоомжийн нийцлийг хангахад шаардлагатай дор дурдсантай холбогдуулан авсан арга хэмжээ;
 - (a) Хуурах, залилан мэхлэх явдлаас урьдчилан сэргийлэх;
 - (b) Хувь хүний мэдээллийг боловсруулах, тараах үйл ажиллагаанд хувь хүний нууцыг хамгаалах, хувь хүний бүртгэл, хувийн хэргийг хамгаалах;
 - (c) Аюулгүй байдал зэрэг.

6 дугаар зүйл

Дотоод үйл ажиллагааны журам

1. Сайд нарын зөвлөл энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хоёр жил тутамд хянана. Энэ зорилгоор, Сайд нарын зөвлөл нь Оролцогч улс бүрийн Засгийн газрын тэргүүнээс эрх олгосны дагуу энэхүү хэлэлцээрийг хянах сайд нараас бүрдэнэ.

2. Байнгын хороо нь энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хянан, удирдан зохион байгуулах бөгөөд гаргасан зөвлөмжөө Сайд нарын зөвлөлд хянуулахаар хүргүүлнэ.

3. 2 дугаар хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор, Байнгын хороо нь Оролцогч улсын холбогдох Засгийн газрын ахлах ажилтнаас бүрдсэн Хөрөнгө оруулалтын ажлын хэсгийг байгуулна.

³Нийтийн дэг журмыг хангах зорилгоор авсан үл хамаарах нөхцөл нь зөвхөн нийгмийн аль нэг суурь эрх ашигт бодитой бөгөөд ноцтой аюул хангалттай хэмжээнд тулгарсан тохиолдолд хөндөгдөнө.

4. Хөрөнгө оруулалтын ажлын хэсэг нь жилд хоёроос доошгүй удаа хуралдах бөгөөд ажлаа Байнгын хороогоор дамжуулан Сайд нарын зөвлөлд тайлагнана.

5. АНДЭЗНК-ын нарийн бичгийн дарга нарын газар нь Хөрөнгө оруулалтын ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нарын газар байна.

7 дугаар зүйл

Оролцогч улс хоорондын маргааныг шийдвэрлэх

1. Энэхүү хэлэлцээрийн зорилгоор энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг байх маргаан шийдвэрлэх тусгай механизм байгуулж болно.

2. Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, эсхүл хэрэглэх асуудлаар Оролцогч улс хооронд үүссэн аливаа маргаантай холбогдуулан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан маргаан шийдвэрлэх тусгай механизмыг байгуулаагүй тохиолдолд, АНДХХ-ийн 20 болон 21 дүгээр зүйлийг *mutatis mutandis* (зохих өөрчлөлттэйгээр) зарчмын дагуу хэрэглэнэ.

8 дугаар зүйл

Тусгайлан анхаарах

1. Энэхүү хэлэлцээрийн дагуу гаргаж өгөх бүх хуваарь, үйл ажиллагааны төлөвлөгөөг хүргүүлэх, хэрэгжүүлэх асуудлаар нэн буурай хөгжилтэй Оролцогч улсад уян хатан хандана. Оролцогч улс өөрийн хуваарь болон үйл ажиллагааны төлөвлөгөөгөөрөө эдгээр улсад зориулан тусгай хөнгөлөлт олгоно.

2. Оролцогч бусад улстай хөрөнгө оруулалтын харилцаагаа өргөжүүлэхэд чиглэсэн техникийн туслалцаа авах, хамтын ажиллагааны тохиролцоо хийх тухай нэн буурай хөгжилтэй Оролцогч улсаас гаргасан хүсэлтийг Оролцогч улс тусгайлан анхаарна.

3. Энэ зүйлийн 1 дүгээр хэсгийн дагуу Шри Ланка Улсыг мөн адил тусгайлан анхаарна.

9 дүгээр зүйл

Нэмэлт, өөрчлөлт оруулах

Энэхүү хэлэлцээр, түүний хуваарь, үйл ажиллагааны төлөвлөгөөнд Оролцогч бүх улсын зөвшөөрлийн дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлт нь Оролцогч бүх улс хүлээн зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болно.

10 дугаар зүйл

Нэмэлт хэлэлцээр болон тохиролцоо

Энэхүү хэлэлцээрийн дагуу бий болсон хуваарь, үйл ажиллагааны төлөвлөгөө, хавсралт болон бусад тохиролцоо, эсхүл хэлэлцээр нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.

11 дүгээр зүйл

Харилцах этгээд

1. Хэлэлцээрийн хэрэгжилт, үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг солилцох зэрэг энэхүү хэлэлцээрийн үйлчлэх хүрээнд хамаарах аливаа асуудлаар Оролцогч улс



хооронд харилцах үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор харилцах этгээдийг томилно.

2. Хүсэлтийг хүлээн авч буй Оролцогч талын харилцах этгээд нь Оролцогч аль нэг талын хүсэлтийн дагуу тухайн асуудлыг хариуцсан байгууллага, эсхүл албан тушаалтныг тогтоон хүсэлт гаргасан Оролцогч талтай харилцах үйл ажиллагааг хөнгөвчлөхөд дэмжлэг үзүүлнэ.

12 дугаар зүйл

Төгсгөлийн заалт

1. Энэхүү хэлэлцээр нь АНДХХ-ийн Үйлчилгээний худалдааг идэвхжүүлэх, чөлөөлөх тухай ерөнхий хэлэлцээртэй зөрчилдөх тохиолдолд Дэлхий худалдааны байгууллагын Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 2(с)-д тодорхойлсон үйлчилгээний худалдааг чөлөөлөх асуудалд АНДХХ-ийн Үйлчилгээний худалдааг идэвхжүүлэх, чөлөөлөх тухай ерөнхий хэлэлцээрийн холбогдох зохицуулалтыг, энэхүү хэлэлцээрийн Хуваарь IV-т заасны дагуу тогтоох хөрөнгө оруулалтыг хамгаалах арга хэмжээнд холбогдох асуудалд энэ хэлэлцээрийн холбогдох зохицуулалтыг тус тус хэрэглэнэ.

2. Энэхүү хэлэлцээр нь хэлэлцээрт гарын үсэг зурсан бүх Засгийн газар хэлэлцээрийг соёрхон баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн батламж жуух бичгээ АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газарт хадгалуулснаар хүчин төгөлдөр болно. АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газар батламж жуух бичгийн баталгаат хуулбарыг Оролцогч улс бүрд нэн даруй хүргүүлнэ. Хэлэлцээрт гарын үсэг зурсан Засгийн газар энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш зургаан сарын дотор соёрхон баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн батламж жуух бичгээ хадгалуулна.

3. АНДХХ-ийн 11 болон 26 дугаар зүйлийн дагуу, энэхүү хэлэлцээр нь АНДХХ-ийн Хавсралт III-С хэсэг болох бөгөөд хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.

ДЭЭРХИЙГ НОТОЛЖ, гарын үсэг зурсан улсын дор дурдсан бүрэн эрхт төлөөлөгчид тус тусын Засгийн газраа төлөөлж энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав. Хэлэлцээрийг хоёр мянга есөн оны арван хоёрдугаар сарын арван тавны өдөр Сөүл хотноо англи хэлээр нэг хувь үйлдэв.

ХУВААРЬ I

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БОЛОН ХӨНГӨВЧЛӨХ ХӨТӨЛБӨР

Оролцогч улс шаардлагатай тохиолдолд Нарийн бичгийн дарга нарын газартай хамтран Хамтын ажиллагааны болон хөнгөвчлөх хөтөлбөрийн талаар дор дурдсан санаачилгыг гаргана:

1. Бие даан:

- (a) Оролцогч улсын хөрөнгө оруулалтын дүрэм, журам, бодлогын талаарх мэдээллийг тогтмол хэвлэн нийтэлж, олон нийтэд хүртээмжтэй байлгах замаар ил тод байдлыг сайжруулах;
- (b) хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зөвшөөрөл өгөх, өргөдөл шийдвэрлэх ажиллагааг бүх шатанд хялбаршуулах, шуурхай болгох;

- (с) Оролцогч улс хоорондын давхар татвараас зайлсхийх тухай хоёр талт хэлэлцээрийн тоог нэмэгдүүлэх.

2. Хамтран:

- (а) АНДХХ-ийг дэмжиж буй аж үйлдвэр болон АНДХХ-ийн технологи нийлүүлэгчийн мэдээллийн санг бий болгох;
- (б) АНДХХ-ийн хөрөнгө оруулалтын боломж, хөрөнгө оруулалтын урсгалын талаарх мэдээллийг нэмэгдүүлэх мэдээллийн санг бий болгох;
- (с) АНДХХ-ийн гадна болон дотор тулгарч буй хөрөнгө оруулалтын саад бэрхшээлийг тодорхойлох зорилгоор АНДХХ-ийн бизнесийн байгууллага болон олон улсын бусад байгууллага хоорондын яриа хэлэлцээг тогтмолжуулах замаар төр, хувийн хэвшил хоорондын харилцааг дэмжих;
- (д) Хүний нөөц, дэд бүтэц, аж үйлдвэр, жижиг, дунд аж ахуйн нэгжийг дэмжих, мэдээллийн технологи, аж үйлдвэрийн технологи, судалгаа болон хөгжүүлэлт зэргээр техникийн хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлох, техникийн хамтын ажиллагаанд оролцдог бусад олон улсын байгууллагатай хамтран АНДХХ-ийн хүрээнд хамтран ажиллах;
- (е) АНДХХ-ийн Давхар татвараас зайлсхийх тухай хэлэлцээр байгуулах боломжийг судлах.

ХУВААРЬ II

ИДЭВХЖҮҮЛЭХ БОЛОН МЭДЛЭГ ОЛГОХ ХӨТӨЛБӨР

Оролцогч улс, шаардлагатай тохиолдолд Нарийн бичгийн дарга нарын газартай хамтран Идэвхжүүлэх болон Мэдлэг олгох хөтөлбөрийн талаар дараах арга хэмжээг авна:

1. Семинар, үзэсгэлэн, яармаг, хөрөнгө оруулалтын форум зэрэг хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх хамтарсан арга хэмжээг зохион байгуулах;
2. Хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх асуудлаар Оролцогч улсын хөрөнгө оруулалтын байгууллага хоорондын зөвлөгөөнийг тогтмол явуулах;
3. Оролцогч улсын хөрөнгө оруулалтын байгууллагын ажилтнуудад зориулан хөрөнгө оруулалттай холбогдох сургалт зохион байгуулах;
4. Оролцогч улс нь Оролцогч бусад улсаас хөрөнгө оруулалт хийхийг уриалж буй салбарын жагсаалтаа солилцож, идэвхжүүлэх арга хэмжээг санаачлах;
5. Оролцогч улсын хөрөнгө оруулалтын байгууллага болон худалдаа аж үйлдвэрийн дээд танхимын зүгээс Оролцогч бусад улсын идэвхжүүлэх хүч чармайлтыг дэмжих боломжит арга замыг судлах;
6. Идэвхжүүлэх үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор Хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх хамтарсан хороог байгуулах.



ХУВААРЬ III

ЧӨЛӨӨЛӨХ ХӨТӨЛБӨР

Чөлөөлөх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс, Оролцогч улсууд АНДХХ-ийн Оролцогч улс хооронд хөрөнгө оруулалтыг илүү чөлөөтэй болгохыг дэмжих зорилгоор хөрөнгө оруулалтын дэглэмээ үе шаттайгаар сайжруулах яриа хэлэлцээ хийхээр тохиролцов.

ХУВААРЬ IV

ХАМГААЛАЛТЫН ХӨТӨЛБӨР

Хамгаалалтын хөтөлбөрийн хүрээнд Оролцогч улс:

1. Хамгаалалтын хөтөлбөрийн хүрээнд, Оролцогч улс АНДХХ-ийн Хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалах тухай хэлэлцээрийг боловсруулж, байгуулна. Тэрхүү хэлэлцээрт дор хаяж дараах асуудлыг тусгана:

- (a) АНДХХ-ийн хөрөнгө оруулагч нарт хөрөнгө оруулалт хийгдсэний дараа үйлчлэх үндэсний нөхцөл, нэн тааламжтай үндэсний нөхцөл;
- (b) АНДХХ-ийн хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалт хүлээн авагч улсын хууль тогтоомжийн дагуу хийсэн хөрөнгө оруулалтыг бүрэн хамгаалж, аюулгүй байдлыг нь хангах, ийм хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулах, удирдан зохион байгуулах, ашиглах, өргөжүүлэх, захиран зарцуулах эсхүл татан буулгахад сөргөөр нөлөөлөх үндэслэлгүй, эсхүл ялгаварлан гадуурхсан арга хэмжээний эсрэг хамгаалалт;
- (c) Нийтийн зорилгоор, эсхүл нийтээр ашиглах, эсхүл нийтийн ашиг сонирхлын төлөө, зохих журмыг баримтлан үл ялгаварлах зарчмын дагуу зохих ёсны, саадгүй, бодитой нөхөн төлбөр олгохоос бусад тохиолдолд албадан хураах, төрийн өмчид авахаас хамгаалах;
- (d) АНДХХ-ийн хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын үр дүнд олсон хөрөнгө, цэвэр ашиг, ногдол ашиг, роялти, техникийн туслалцаа, техникийн төлбөр, хүү болон бусад орлого, түүний дотор төлбөрийн тэнцлийг хамгаалах арга хэмжээ;
- (e) Хөрөнгө оруулалттай холбоотойгоор Оролцогч улс хооронд, эсхүл Оролцогч аль нэг улс болон Оролцогч өөр нэг улсын хөрөнгө оруулагч хооронд үүссэн хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх журам;
- (f) Үйл ажиллагааны шалгуур тогтоож, хэрэгжүүлэх.

2. Дор хаяж, Дэлхийн худалдааны байгууллагын Худалдаанд хамаарах оюуны өмчийн тухай хэлэлцээрийн зарчим, дүрмийн дагуу оюуны өмчийн эрхийн зарчмыг хамгаалах, хүлээн зөвшөөрөх.

5. АЗИ, НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХОЁР ДАХЬ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс болон Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улс;

Сайд нарын зөвлөлийн гуравдугаар чуулганы үеэр Сөүл хотноо 2009 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан Сайд нарын тунхаглалын “бүх-Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр” болохын хувьд яриа хэлэлцээг хамтын ажиллагааны нэмэлт салбараар өргөжүүлэх, тарифын хөнгөлөлтийг нэмэгдүүлэх чиглэлийг Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн Байнгын хороонд өгсөн шийдвэрийг эргэн **САНАЖ**;

Тарифын хөнгөлөлтийн Дөрөв дэх шатны яриа хэлэлцээ үүгээр дуусгавар болж, Гарал үүслийн дүрмийг амжилттай хэлэлцсэнийг тэмдэглэн, эдгээр шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор АНДХХ-т 26 дугаар зүйлийнх нь дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатайг **ТЭМДЭГЛЭЖ**;

Дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулав:
 - (i) Үндэсний хөнгөлөлтийн жагсаалт (АНДХХ-ийн Хавсралт I)-ыг шинэ жагсаалтаар сольж энэхүү Хоёр дахь нэмэлт, өөрчлөлтөд хавсаргав.
 - (ii) Гарал үүслийн дүрэмд (АНДХХ-ийн Хавсралт II):
 - а) Дараах зүйлийг 9 дэх зүүлт тайлбар хэлбэрээр нэмэв:

4 ДҮГЭЭР ДҮРЭМ: “НИЙЛМЭЛ АГУУЛАМЖ” ГЭХ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР”

4 дүгээр дүрэмд заасан “нийлмэл агууламж”-ийг орц болгон ашигласан гарал үүсэл бүхий материалын үнэ (ГҮМҮ1) болон эцсийн бүтээгдэхүүнийг боловсруулсан Оролцогч улсаас нэмсэн гарал үүсэл бүхий материалын үнийн (ГҮМҮ2) дүнгийн нийлбэрээр тооцож бодно.

ГҮМҮ1 гэж өмнөх Оролцогч улсын нутаг дэвсгэрээс гаралтай бүтээгдэхүүний үнийг хэлэх бөгөөд уг үнийг Гаалийн үнэлгээний хэлэлцээрийн 1-8 дугаар зүйл, 15 дугаар зүйл болон холбогдох тайлбарын дагуу тодорхойлсон гаалийн үнэд үндэслэн тооцоолно.

ГҮМҮ2 гэж эцсийн бүтээгдэхүүнийг боловсруулсан Оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарал үүсэл бүхий материалын үнэ болон шууд хөдөлмөрийн хөлс, шууд нэмэлт зардал, тээврийн зардал болон эцсийн бүтээгдэхүүний ашиг зэрэг тухайн Оролцогч улсад эцсийн бүтээгдэхүүнийг боловсруулахад ашигласан орцын үнийг хэлнэ. Дээрх тайлбарын дагуу ГҮМҮ1 болон ГҮМҮ2 –ийн нийлбэр f.o.b үнийн 60 хувиас багагүй бол тухайн бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүнийг боловсруулсан Оролцогч улсын нутаг дэвсгэрээс гарал үүсэлтэй гэж үзнэ.

- b) Дараах зүйлийг 10 дахь зүүлт тайлбар хэлбэрээр нэмэв:

“5 ДУГААР ДҮРМИЙН 5(b)(ii): “БАРААГ ШУУД АЧИХ” ГЭХ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР”

Дүрмийн 5(b)(ii) дахь хэсгийн “тухайн бүтээгдэхүүн нь дамжин өнгөрсөн улсад худалдаа, эсхүл хэрэглээнд ороогүй” гэснийг Оролцогч бус дундын улсын гаалийн байгууллагын хяналтад байгаа боловч импортын хяналт, шалгалт хийлгээгүй



бүтээгдэхүүнийг экспортлогч Оролцогч улсаас импортлогч Оролцогч улс руу шууд ачуулсан гэж тайлбарлана.

“Худалдаанд, эсхүл хэрэглээнд орсон бүтээгдэхүүн” гэх нэр томъёог тухайн бүтээгдэхүүний импортын мэдэгдлийг хүлээн авсан бөгөөд хэрэглэх, эсхүл өөр гэрээний дагуу эсхүл зорилгоор гаалийн хяналтын бүсээс дундын улсын дотоодын зах зээл рүү гаргасан бүтээгдэхүүн гэж ойлгоно. Иймээс гаалийн байгууллагын хяналт дор гаалийн хяналтын бүсэд түр хадгалагдаж байгаа бөгөөд Дүрмийн 5(b)(iii) дахь хэсэгт тодорхойлсноос өөр үйл ажиллагаа хийгдээгүй бол уг бүтээгдэхүүнийг худалдаанд, эсхүл хэрэглээнд ороогүй гэж ойлгоно.

с) Энэхүү Хоёр дахь нэмэлт, өөрчлөлтийн Хавсралт II.A-г 3 дугаар дүрмийн 3(b) хэсгийн дагуу Салбар хоорондын хэлэлцээр гэж хавсаргав.

2. Энэхүү Хоёр дахь нэмэлт, өөрчлөлтийг АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газарт хадгалуулна. Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газар нь баталгаат хуулбарыг Оролцогч улс бүрд нэн даруй хүргүүлнэ.

3. Энэхүү Хоёр дахь нэмэлт, өөрчлөлт нь Оролцогч бүх улс соёрхон баталсан, эсхүл хүлээн зөвшөөрсөн тухай батламж жуух бичгээ АНДЭЗНК-ын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нарын газарт хадгалуулснаар хүчин төгөлдөр болно.

ДЭЭРХИЙГ НОТОЛЖ, гарын үсэг зурсан улсын дор дурдсан бүрэн эрхт төлөөлөгчид тус тусын Засгийн газраа төлөөлж энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

Хэлэлцээрийг хоёр мянга арван долоон оны нэгдүгээр сарын арван гуравны өдөр Тайланд Улсын Банкок хотноо англи хэлээр нэг хувь үйлдэв.

6. АЗИ, НОМХОН ДАЛАЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХҮРЭЭНД БАРААНЫ ГАРАЛ ҮҮСЛИЙГ НОТЛОХ ГЭРЧИЛГЭЭ ОЛГОЖ, БАТАЛГААЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

2005 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр байгуулсан Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт Оролцогч талууд (цаашид “Оролцогч улс орнууд” гэх):

Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (цаашид “АНДХХ” гэх)-ийн гарал үүслийн дүрмийг хэрэгжүүлэх зорилгоор гарал үүслийг нотлох гэрчилгээ олгох, баталгаажуулах болон холбогдох бусад захиргааны асуудлыг шийдэх үйл ажиллагааны журмыг боловсруулах талаар дараах зүйлсийг харилцан тохиролцов.

1 дүгээр зүйл

Эрх бүхий байгууллагууд

(1) Гарал үүслийн гэрчилгээг барааг экспортолж байгаа Оролцогч улс орны Засгийн газраас томилсон эрх бүхий байгууллага/байгууллагууд (цаашид “Эрх бүхий байгууллагууд” гэх) олгоно.

(2) Оролцогч улс орон бүр өөрсдийн холбогдох олгох эрх бүхий байгууллагын нэр, хаягийг бусад Оролцогч улс орнуудад мэдэгдэж, гарал үүслийн гэрчилгээг баталсан албан ёсны тамганы загварыг хүргүүлнэ. Дээрх мэдээлэл болон загварт аливаа өөрчлөлт орсон бол бусад Оролцогч улс орнуудад цаг тухайд нь нэн даруй мэдэгдэнэ.

2 дугаар зүйл

Өргөдөл

(1) Хөнгөлөлтөд хамрах болзлыг хангасан бүтээгдэхүүнийг экспортлогч ба /эсвэл үйлдвэрлэгч нь экспортлохоос өмнө тухайн бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах

буюу бүртгүүлэхийг хүсч, холбогдох эрх бүхий байгууллагад бичгээр (гараар эсвэл цахим хэлбэрээр) өргөдөл гаргана. Баталгаажуулалт болон бүртгэлийн үр дүнг үе үе, эсвэл шаардлагатай тохиолдолд хянан үзэх ёстой бөгөөд үүнийг экспортлох гэж байгаа холбогдох бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах нотлох баримт болгон хүлээн авна. Шинж чанараар нь гарал үүслийг нь хялбархан баталгаажуулах боломжтой бүтээгдэхүүний хувьд экспортоор гаргахаас өмнөх баталгаажуулалтыг шаардахгүй байж болно.

(2) Хөнгөлөлтөд хамрах нөхцөлөөр экспортлох бүтээгдэхүүний ёс журмын ажиллагааг хэрэгжүүлэх үед экспортлогч буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч гарал үүслийн гэрчилгээ олгохыг хүсэж бичгээр (гараар эсвэл цахим хэлбэрээр) олгох эрх бүхий байгууллагад өргөдөл гаргаж, экспортлох бүтээгдэхүүн нь гарал үүслийн гэрчилгээ олгох шаардлага хангасан болохыг нотлох зохих баримт бичгийн хамт холбогдох журмын дагуу бөглөсөн гарал үүслийн гэрчилгээг хүргүүлнэ.

(3) Олгох эрх бүхий байгууллагууд гарал үүслийн гэрчилгээ авах өргөдлийг баталгаажуулахдаа тухайн бараа нь АНДХХ -ийн гарал үүслийн дүрэм болон энэхүү дүрэмд нийцэж байгаа эсэхийг шалгахын тулд өргөдөл гаргагчаас аливаа дагалдах баримт бичгийг шаардах эрхтэй.

(4) Олгох эрх бүхий байгууллагууд гарал үүслийн гэрчилгээ авах өргөдөл бүрийг нарийвчлан шалгаж, дараах зүйлст нийцэж байгаа эсэхийг тогтооно:

(a) өргөдөл, гарал үүслийн гэрчилгээг зохих журмын дагуу бөглөж, экспортлогч эсвэл гарын үсэг зурах эрх бүхий этгээд гарын үсэг зурсан эсвэл цахим хэлбэрээр ирүүлсэн;

(b) барааны гарал үүсэл нь АНДХХ -ийн гарал үүслийн дүрэмд нийцсэн байх;

(c) гарал үүслийн гэрчилгээн дээрх бусад мэдэгдэл/оруулсан бичилт нь дагалдах нотлох баримттай тохирсон байх;

(d) барааны тарифын ангилал, тодорхойлолт, барааны хэмжээ, жин, тэмдэг, баглаа боодлын тоо, багцын тоо, төрөл нь экспортлох бараатай тохирч байх.

3 дугаар зүйл

Гарал үүслийн гэрчилгээ

(1) Гарал үүслийн гэрчилгээ нь англи хэл дээр хэвлэгдсэн АНДХХ -ийн II Хавсралтад заасан загвар бичвэрийн дагуу ISO A4 хэмжээтэй цаасан дээр хийгдсэн байна.

(2) Гарал үүслийн гэрчилгээ нь нэг эх хувь, олгох эрх бүхий байгууллагад хадгалагдах нэг хувь эсвэл хуулбараас бүрдэнэ. Гарал үүслийн гэрчилгээний өнгийг бараа экспортлох Оролцогч улс орон бүр тодорхойлж, бусад Оролцогч улс орон, Нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

(3) Гарал үүслийн гэрчилгээ бүр олгосон газар тус бүрээс тусад нь олгосон үл давтагдах дугаартай байна.

(4) Эх хувийг экспортлогч барааг импортлох боомт эсвэл газар дахь Гаалийн байгууллагад хүргүүлэхээр импортлогч руу хүргүүлнэ.

4 дүгээр зүйл

Гарал үүслийн гэрчилгээ олгох

(1) Оролцогч улс орны гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагууд барааг экспортлох үед, эсвэл экспортлох бүтээгдэхүүн АНДХХ-ийн гарал үүслийн дүрмийн дагуу Оролцогч улс орны гарал үүсэлтэй гэж тооцогдох боломжтой бол ачуулсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор гарал үүслийн гэрчилгээг гараар эсвэл цахим хэлбэрээр олгоно. Гарал үүслийн гэрчилгээ нь олгосон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.



(2) Гарал үүслийн гэрчилгээн дээрх зүйлсийг арилгах, дарж бичихийг хориглоно. Ашиглагдаагүй хоосон зайг дараа нь нэмж юм бичихээс урьдчилан сэргийлэх үүднээс хэрээс тавина.

(3) АНДХХ -ийн II Хавсралтын Дүрмийн 2, 3 эсвэл 4-ийн дагуу экспортлогч Оролцогч улс орны эрх бүхий байгууллага гарал үүслийн гэрчилгээний 8-р хүснэгтэд холбогдох дүрэм журам, бүс нутгийн гарал үүслийн агуулагдах хувийг зааж өгнө.

(4) Гарал үүслийн гэрчилгээ хулгайлагдсан, алдагдаж гээгдсэн, устгагдсан тохиолдолд экспортлогч эх хувийг баталгаажуулсан жинхэнэ хуулбарыг авахын тулд гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагад бичгээр хүсэлт гаргаж болно. Хуулбарыг гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагын баримтад хадгалагдсан холбогдох баримт бичгийг үндэслэн хийнэ. Энэхүү хуулбар нь "БАТАЛГААЖСАН ЖИНХЭНЭ ХУВИЛБАР" гэсэн үгийг болон гарал үүслийн гэрчилгээний эх хувийг гаргасан огнооны хамтаар 3 -р хүснэгтэд бичсэн байвал зохино. Гарал үүслийн гэрчилгээний баталгаажсан жинхэнэ хуулбарыг гарал үүслийн гэрчилгээ хүчин төгөлдөр байх хугацаанд олгоно.

5 дугаар зүйл

Гарал үүслийн гэрчилгээг үзүүлэх

(1) Гарал үүслийн гэрчилгээний эх хувийг холбогдох бүтээгдэхүүнийг импортоор нэвтрүүлэх үед хөнгөлөлттэй нөхцөлд хамрагдахын тулд Гаалийн байгууллагад үзүүлнэ.

(2) Гарал үүслийн гэрчилгээ хүчин төгөлдөр байх хугацаанд уг барааг импортолж байгаа Оролцогч улс орны гаалийн байгууллагад хүргүүлнэ.

(3) Гарал үүслийн гэрчилгээг хүчин төгөлдөр байх хугацаа нь дууссаны дараа бараа импортолж байгаа Оролцогч улс орны холбогдох гаалийн байгууллагад хүргүүлсэн тохиолдолд тийнхүү хугацааг дагаж мөрдөөгүй нь экспортлогч хянаж чадахааргүй давагдашгүй хүчин зүйл буюу бусад тооцохоос өөр аргагүй шалтгаанаас үүдэлтэй тохиолдолд уг гэрчилгээг хүлээн авч болно.

(4) Бараа бүтээгдэхүүнийг гарал үүслийн гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө импортолсон бол барааг импортолж байгаа Оролцогч улс орны холбогдох гаалийн байгууллага бүх тохиолдолд уг гарал үүслийн гэрчилгээг хүлээн авч болно.

(5) Бүтээгдэхүүний гарал үүсэл нь эргэлзээгүй бөгөөд гарал үүслийн гэрчилгээнд оруулсан мэдэгдэл болон барааг импортолж байгаа Оролцогч улс орны гаалийн байгууллагад барааг импортлохын тулд ёс журмын ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор ирүүлсэн баримт бичгийн хооронд ялимгүй зөрүү илэрсэн тохиолдолд гарал үүслийн гэрчилгээ нь тухайн бараа бүтээгдэхүүнтэй яг үнэндээ таарч байгаа бол гарал үүслийн гэрчилгээг хүчингүй болгохгүй.

6 дугаар зүйл

Гарал үүслийг баталгаажуулах⁴

(1) Барааг импортолж байгаа Оролцогч улс орны Гаалийн байгууллага нь барааг экспортолж байгаа Оролцогч улс орны эрх бүхий байгууллагад баримт бичиг жинхэнэ эсэх, холбогдох бараа бүтээгдэхүүний гарал үүслийн статус үнэн зөв эсэх талаар ямар нэг эргэлзэх зүйл байгаа тохиолдолд өмнө нэвтрүүлсэн барааны тухайд түүвэр шалгалт хийлгэх хүсэлт гаргаж болно.

⁴БНСУ-ын хувьд гарал үүслийг баталгаажуулах зорилго бүхий «Олгох эрх бүхий байгууллага» гэсэн нэр томъёо нь Гаалийн байгууллагад хамаарна.



(2) Хүсэлтэд холбогдох гарал үүслийн гэрчилгээг хавсаргасан байх ёстой бөгөөд хүсэлтийн шалтгаан болон дурдсан гарал үүслийн гэрчилгээнд заасан мэдээлэл буруу байж болзошгүйг харуулсан нэмэлт мэдээллийг хүсэлтэд тодорхой зааж өгнө.

(3) Барааг импортолж байгаа Оролцогч улс орны гаалийн байгууллага баталгаажуулалтын үр дүнг хүлээх зуураа хөнгөлөлтөд хамрагдах нөхцөлийг түдгэлзүүлж болно. Гэсэн хэдий ч импортын хориг, хязгаарлалтад хамаарахгүй, луйвар хийсэн гэх сэжиг байхгүй тохиолдолд л шаардлагатай гэж үзсэн захиргааны арга хэмжээний дагуу импортлогчид барааг нь олгож болно.

(4) Баталгаажуулах хүсэлтийг хүлээн авсан гэрчилгээ олгох эрх бүхий байгууллага нь хүсэлтэд шуурхай хандаж, хүсэлтийг хүлээн авснаас хойш гурван (3) сарын дотор хариу өгөх ёстой. Асуудлыг бодитойгоор авч үзэх, холбогдох бараа бүтээгдэхүүн нь тухайн орны гарал үүсэлтэй эсэхийг тодорхойлох зэрэг ажлыг багтаасан баталгаажуулалтын үйл ажиллагааг дуусгаж, үр дүнг зургаан (6) сарын дотор олгох эрх бүхий байгууллагад хүргүүлэх ёстой. Баталгаажуулах үйл ажиллагаа хийгдэж байх үед дэд хэсэг (3)-ыг мөрдөнө. Хүсэлт гаргаснаас хойш дөрвөн (4) сарын дотор барааг импортолж байгаа Оролцогч улс орны гаалийн байгууллагад хариу ирүүлээгүй тохиолдолд гаалийн байгууллага хөнгөлөлттэй нөхцөл олгох тухай нэхэмжлэлээс татгалзаж болно. Ирүүлсэн хариу нь баримт бичгийн жинхэнэ эсэх эсвэл барааны гарал үүслийг баталгаажуулахад хангалттай мэдээлэл агуулаагүй тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагууд асуудлыг гурван (3) сарын дотор хоёр тал зөвлөлдсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.

7 дугаар зүйл

Бүртгэл хөтлөхөд тавигдах шаардлага

(1) Гарал үүслийн гэрчилгээ авах өргөдөл болон ийм өргөдөлтэй холбоотой бүх баримт бичгийг гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагууд олгосон өдрөөс хойш хоёроос доошгүй жилийн хугацаанд хадгална.

(2) Гарал үүслийн гэрчилгээний үнэн зөв байдалтай холбоотой мэдээллийг бараа импортолж байгаа Оролцогч улс орны хүсэлтээр ирүүлнэ.

(3) Оролцогч улс орнуудын хооронд дамжуулсан аливаа мэдээллийг нууцын зэрэгтэйд тооцох тул зөвхөн гарал үүслийн гэрчилгээг баталгаажуулахад ашиглана.

8 дугаар зүйл

Тусгай кейсүүд

Оролцогч улс орны тогтоосон боомт руу экспортолж буй бүтээгдэхүүнийг бүгдийнх нь эсвэл зарим хэсгийн очих газрыг өөрчлөх тохиолдолд бараа импортолж байгаа Оролцогч улс оронд ирэхээс өмнө буюу ирсний дараа нь дараах дүрмийг баримтална.

(1) Бараа бүтээгдэхүүнийг тэдгээрийг импортолж байгаа Оролцогч улс орны гаалийн байгууллагад аль хэдийнэ ирүүлсэн бол импортлогчийн бичгээр гаргасан өргөдлийн дагуу гарал үүслийн гэрчилгээг дээрх байгууллагууд бараа бүтээгдэхүүнийг бүгдийг нь эсвэл зарим хэсгийнх нь хувьд баталгаажуулах бөгөөд эх хувийг нь импортлогчид буцааж өгнө.

(2) Гарал үүслийн гэрчилгээнд заасны дагуу барааг импортолж байгаа Оролцогч улс орон руу шууд тээвэрлэх явцад очих газар өөрчлөгдсөн бол экспортлогч бараа бүтээгдэхүүнийг нь эсвэл зарим хэсгийг хамарсан шинэ гарал үүслийн гэрчилгээ олгуулахаар бичгээр өргөдөл гаргаж, өмнө олгосон гарал үүслийн гэрчилгээг хавсаргана.



9 дүгээр зүйл

Шууд тээвэрлэх явцад дагалдах баримт бичиг

АНДХХ -ийн II хавсралтын 5 (b) дүрмийн дагуу Оролцогч улс орнуудын гаднах бусад нутаг дэвсгэрээр барааг тээвэрлэж байгаа тохиолдолд барааг импортолж байгаа Оролцогч улс орны гаалийн байгууллагад дараах баримт бичгийг ирүүлнэ:

- (1) барааг экспортолж байгаа Оролцогч улс оронд гаргасан ачаа тээврийн баримт бичиг;
- (2) барааг экспортолж байгаа Оролцогч улс орны гэрчилгээ олгох эрх бүхий байгууллагаас олгосон гарал үүслийн гэрчилгээ;
- (3) холбогдох бараанд хамаарах арилжааны нэхэмжлэхийн эх хувь; болон
- (4) АНДХХ -ийн II Хавсралтын 5 (b) дүрэмд нийцэж байгааг нотлох баримт бичиг.

10 дугаар зүйл

Оролцогч улс орнуудын хамтын ажиллагаа

(1) Гарал үүслийн гэрчилгээтэй холбоотой луйвар хийсэн гэж сэжиглэж байгаа тохиолдолд холбогдох Оролцогч улс орнуудын эрх бүхий байгууллагууд тухайн хүмүүст арга хэмжээ авах чиглэлээр хамтран ажиллаж, луйврын эсрэг дотоодын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

(2) Гарал үүслийг тодорхойлох, барааны ангилал, бараа бүтээгдэхүүн болон бусад асуудлаар аливаа маргаан гарсан тохиолдолд барааг импортолж байгаа болон экспортолж байгаа Оролцогч улс орнуудын холбогдох эрх бүхий байгууллагууд маргааныг шийдвэрлэх зорилгоор харилцан зөвлөлдөх ба үр дүнг бусад Оролцогч улс орнуудад мэдэгдэнэ.

(3) Оролцогч улс орон бүр АНДХХ-ийн гарал үүслийн дүрмийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд холбоо баригч эсвэл холбоо баригч нарыг томилно.

11 дүгээр зүйл

Үзэсгэлэнгийн зорилго

(1) Барааг импортолж байгаа Оролцогч улс орны засгийн газрын холбогдох байгууллагуудын шаардлагыг дараах байдлаар хангаж байгаа бол Оролцогч нэг улс орноос Оролцогч нөгөө улс оронд үзэсгэлэнд тавихаар илгээсэн бөгөөд үзэсгэлэнгийн үеэр эсвэл дараа нь зарж борлуулсан бүтээгдэхүүнүүд нь АНДХХ-ийн гарал үүслийн дүрмийн шаардлагыг хангасан нөхцөлд АНДХХ -д заасны дагуу тарифын хөнгөлөлтийг эдэлнэ:

- (a) экспортлогч холбогдох бүтээгдэхүүнийг тэдгээрийг экспортолж байгаа Оролцогч улс орны нутаг дэвсгэрээс үзэсгэлэн гарч буй импортолж байгаа Оролцогч улс орон руу илгээж, тэнд үзүүлэхээр байрлуулсан;
- (b) экспортлогч бараагаа зарж борлуулсан эсвэл импортолж байгаа Оролцогч улс оронд ачаа хүлээн авагчид шилжүүлсэн; болон
- (c) бараа бүтээгдэхүүнийг үзэсгэлэнгийн үеэр эсвэл тэр даруйд нь барааг үзэсгэлэнд илгээсэн байдлаар нь тэдгээрийг импортолж байгаа Оролцогч улс оронд зарж борлуулсан.

(2) Дээрх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор гарал үүслийн гэрчилгээг барааг импортолж байгаа Оролцогч улс орны холбогдох төрийн байгууллагад гаргах ёстой.

(3) 1 дэх дэд хэсэг нь аливаа үйл явдлын үеэр бараа бүтээгдэхүүн нь гаалийн хяналтад байх ёстой үзэсгэлэн, яармаг эсвэл ижил төстэй шоу, үзүүлэн зэрэгт хамаарна.



Хаяг: 14210 Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Энх тайвны өргөн чөлөө-7а
Утас: 51-262034
Цахим шуудан host@mfa.gov.mn

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: tugin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 58.25

Индекс: 200003